



2024 оны 3-р сар

Боловсролын үнэлгээний төв

ЭЛСЭГЧИЙН СОНИН

Дугаар №1

www.eec.mn



МЭНДЧИЛГЭЭ

Их дээд сургуульд элсэгчдийн сурах ерөнхий чадварыг шалгах ЭШ-ын бүртгэл орон даяар зохион байгуулагдаж буй энэ цаг мөчид 12-р анги төгсөгч болон нийт шалгуулагч, багш, эцэг эхчүүд та бүхэнтэй "Элсэгчийн сонин"-оор дамжуулан мэндчилж байгаадаа баяртай байна.

Боловсролын үнэлгээний төв байгууллага хуулиар олгогдсон үндсэн чиг үүргийн хүрээнд боловсролын үйлчилгээг орчин үеийн мэдээллийн технологийн дэвшил, инновацийн хөгжлийг ашиглан боловсролын үнэлгээнд тулгамдаад байсан сэдэв даалгаврын нууцлал, дүн онооны ил тод байдал, үнэлгээний үр дүнд суурилсан эргэх холбоо зэрэг боловсролын талаарх бодлого шийдвэртэй холбоотой олон асуудлыг шийдвэрлэх зорилгоор цахим шилжилтүүдийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсээр ЭШ-ыг энэ хичээлийн жилд 18 дахь жилдээ зохион байгуулах гэж байна.

2022 оноос эхлэн ЭШ-ыг жилд 2 удаа зохион байгуулж байна. Мөн шалгалтын дүн онооны ил тод, бодит найдвартай байдлыг хангах зорилгоор Блокчейн технологи, статистик мэдээ, үр дүнгийн мэдээллийг BI / Business Intelligence/ системд байршуулах зэрэг технологийн хурдацтай дэвшлүүдийг ашиглаж байна.

Та бүхнийг БҮТ-ийн үндсэн цахим хуудас www.eec.mn, ЭШ-ын мэдээ мэдээллийг нэг дороос хүлээн авах www.help.eec.mn, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөч сайт www.my.future.mn, даалгаврын сангийн www.stat.eec.mn цахим хуудсууд болон гар утасны ЕЕС апплейкшнийг тогтмол ашиглан үнэн бодит мэдээ, мэдээллийг цаг алдалгүй авч байгаарай гэж зөвлөө.

Эзэмших мэргэжил, шалгалт өгөх хичээл, элсэн суралцах сургуулиа сонгохдоо аав ээж, багш, анд нөхөдтэйгээ зөвлөлдөн өөрийн авьяас билиг, хүсэл сонирхолдоо нийцүүлэн цаг заваа сайн төлөвлөж, хариуцлагатай хандаж хүссэн сургуульдаа элсэж ирээдүйн их хөгжлийн түүчээ болон гялалзахын ерөөл өргөө.

БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ

Лхагвасүрэнгийн ГАНБАТ

МОНГОЛ ХЭЛ БИЧГИЙН ШАЛГАЛТ - 2024

БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

2024 МОНГОЛ ХЭЛ БИЧГИЙН ШАЛГАЛТ

2024 САРЫН 06-НЫ ӨДӨР
ЗОХИОН БАЙГУУЛАГДАНА.

EYESH.EEC.MN

ВЭБ САЙТ WWW.EEC.MN ЛАВЛАХ УТАС 7011 9498

МОНГОЛ ХЭЛ БИЧГИЙН ШАЛГАЛТ - 2024

МОНГОЛ ХЭЛ БИЧГИЙН ШАЛГАЛТ - 2024

БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

2024 ОНЫ ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТЫН ХУВААРЬ

2024.07.04	10:00-11:20 ТҮҮХ 13:00-14:20 АНГЛИ ХЭЛ	2024.07.05	10:00-11:40 ХИМИ 13:00-14:20 ГАЗАР ЗҮЙ 16:30-17:50 НИЙГЭМ СУДЛАЛ
2024.07.06	10:00-11:20 БИОЛОГИ 13:00-14:40 МАТЕМАТИК 15:30-16:50 ОРОС ХЭЛ	2024.07.07	10:00-11:40 ФИЗИК 13:00-14:20 МОНГОЛ ХЭЛ

АНХААРАХ ЗҮЙЛ: Шалгалтын байранд 1 цагийн өмнө ирсэн байх. Анги, танхимд 10 минутын өмнө судлаа эзлсэн байна. Дурдсан хугацаанаас хожимдсон шалгуулагчийг шалгалтад оруулахгүй.

ВЭБ САЙТ WWW.EEC.MN ЛАВЛАХ УТАС 7011 9498

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ - 2024



**БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/60

Улаанбаатар хот

**2024 оны Элсэлтийн шалгалтын
удирдамж батлах тухай**

Боловсролын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.11 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын "Монгол хэлбичгийн боловсролыг сайжруулах арга хэмжээний тухай" 2013 оны 37 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/66 дугаар тушаалаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам", Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/594 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагын дүрэм"-ийн 4.4 дүгээр зүйлийн 4.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "2024 оны Элсэлтийн шалгалтын удирдамж"-ийг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан удирдамжийг Элсэлтийн шалгалтын зохион байгуулалтын үйл ажиллагаанд мөрдөж ажиллахыг Үнэлгээний хэлтсийн дарга /М.Гантуяа/, Мэдээлэл технологийн хэлтсийн дарга /Э.Цэрэнцоодол/, Даалгаврын сангийн хэлтсийн дарга /С.Гэндэнжамц/, байгууллагын цахим хуудас /www.eec.mn/-д байршуулахыг, Хэвлэл мэдээллийн мэргэжилтэн /Д.Отгонбаатар/ нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, Удирдлагын хэлтсийн дарга /З.Дайриймаа/-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Л.ГАНБАТ

4.3.2 Өнгөт цээж зургийг файлаар бэлдэх /цээж зураг нь 3*4 хэмжээтэй, сүүлийн 3 сарын дотор авхуулсан, урагшаа цөх харсан, арын фон нь цайвар цулгүй өнгийн, нарны шил болон малгайгүй байна/.

4.3.3 Бүх банкны интернэт гүйлгээ хийх эрхтэй төлбөрийн карт болон Орау үйлчилгээ бүхий банкны аппликэйшн.

4.3.4 Шалгуулагч бүр зөвхөн өөрийн и-мэйл хаягаар бүртгүүлнэ.

4.4 Өмнөх онд төгссөн шалгуулагч шалгалт өгөх аймаг /хот/-аа өөрөө сонгож бүртгүүлнэ.

4.5 Бүртгэл хийгдсэнээс хойш шалгуулагчийн овог, нэр Улсын бүртгэлийн ерөнхий газрын бүртгэлд солигдсон бол шалгуулагч холбогдох бичиг баримт, хүсэлтийг БҮТ-д гарган мэдээллээ дахин баталгаажуулна.

4.6 Энэ онд төгсөж буй шалгуулагч сургууль, анги, бүлэг, овог нэр, регистрийн дугаар зөрүүтэй бол сурч буй сургуулийн сургалтын алба /сургалтын менежер/-аар дамжуулан Боловсролын цахим мэдээллийн сан /esis.edu.mn/-д мэдээллийг засварласны дараа www.eec.mn цахим хуудасны "шалгуулагчийн булан"-аар орж "зөвшөөрөх" товчлуур дарж баталгаажуулна.

4.7 Гадаад улс оронд бүрэн дунд боловсрол буюу түүнээс дээш боловсрол эзэмшсэн иргэн шалгалтад бүртгүүлэхдээ бүрэн дунд боловсрол эзэмшсэнийг гэрчлэх бичиг баримтыг Боловсролын ерөнхий газар /цаашид БЕГ гэх/-аар баталгаажуулж, БҮТ-өөс элсэлтийн шалгалтад орох албан бичиг авна.

4.8 Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон тусгай сургуулийн суралцагч ЭШ-д хамрагдахаар бүртгүүлсэн бол өргөдөл (ямар нөхцөлөөр шалгалт өгөх боломжтой эсэх), эмчийн магадлагааг бүртгэлийн хугацаанд БҮТ-д ирүүлнэ.

4.9 Шалгуулагч нь бүртгүүлсэн утасны дугаараа ашиглан 133233 тусгай дугаараас өөрийн /нууц дугаар, бүртгэлийн дугаар, шалгалтын хуваарь, суудлын хуваарь, дүнгийн мэдээлэл/ мэдээллийг SMS үйлчилгээгээр авах боломжтой.

4.10 Шалгуулагч бүртгэлийн хугацаанд бүртгэлийн дугаар, нууц үгээ ашиглан www.eec.mn цахим хуудасны "шалгуулагчийн булан"-д нэвтэрч шалгалт өгөх хичээлээ нэмж болно. Сонгож баталгаажуулсан хичээлийг хасах болон солих боломжгүй.

4.11 МХБШ нь үнэ төлбөргүй бөгөөд ЭШ-ын нэг хичээлийн бүртгэлийн хураамж 5800 төгрөг байна.

4.12 Шалгуулагч шалгалтын хураамжийг арилжааны бүх банкны интернэт гүйлгээний эрхтэй төлбөрийн карт болон Орау үйлчилгээг ашиглан шилжүүлнэ.


4.13 Шалгуулагч бүртгэлээ бүртгэлийн хугацаанд цуцлан шалгалтын хураамжийг эргүүлэн авах хүсэлтээ гаргасан тохиолдолд тухайн шалгуулагчийн бичиг баримт, өргөдөл, төлбөр төлсөн хуулгыг /банкны теллерийн тамгатай/ үндэслэн олгоно.

4.14 Шалгалтад ороогүй тохиолдолд шалгалтын хураамжийг эргүүлэн олгохгүй, бусдад шилжүүлэн тооцохгүй.

4.15 Шалгуулагч бүртгүүлэх явцад төлбөрийн гүйлгээг давхардуулж хийсэн тохиолдолд бүртгэлийн хугацаанд болон бүртгэл дууссанаас хойш ажлын 10 хоногийн дотор БҮТ-д хандаж төлбөрийн буцаалт хийх тухай хүсэлт гаргаж болно.

4.16 2024 онд ерөнхий боловсролын сургууль төгсөж буй бүртгүүлэгч www.eec.mn цахим хуудасны "шалгуулагчийн булан"-аас QR код бүхий "бүртгэлийн хуудас"-аа хэвлэн авч сургуулийн захирлаар гарын үсэг зуруулан,

Боловсролын үнэлгээний төвийн захирлын
2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн
А/60 дугаар тушаалын хавсралт



2024 ОНЫ ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү удирдамжийг Монгол Улсын хэмжээнд их, дээд сургууль, коллежид элсэгчдийн мэдлэг, чадварын түвшинг тогтоох Элсэлтийн шалгалт /цаашид ЭШ гэх/, эх хэлний боловсролын чанар, хэрэглээ, иргэдийн харилцааны соёл, эх хэлний дархлааны түвшинг тогтоох, сайжруулах зорилго бүхий Монгол хэл бичгийн шалгалт /цаашид МХБШ гэх/-ыг зохион байгуулах харилцааг зохицуулахад удирдлага болгоно.

1.2 Элсэлтийн шалгалт болон Монгол хэл бичгийн шалгалтыг Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Их, дээд сургуульд оюутан элсүүлэх журам болон элсэлтийн шалгалтын журмын холбогдох заалтад нийцүүлэн зохион байгуулна.

Хоёр. Зорилго

Элсэлтийн шалгалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулж, шалгалтын бэлтгэл үйл ажиллагааг хангах, шалгалт зохион байгуулах, үр дүнг тайлагнах, хариуцлагыг тодорхойлоход энэхүү удирдамжийн зорилго оршино.

Гурав. Шалгалтын хамрах хүрээ

Элсэлтийн шалгалтыг 2024 онд бүрэн дунд боловсрол эзэмшсэн ЕБС-ийн төгсөгч /цаашид энэ онд төгссөн шалгуулагч гэх/, 2024 онд Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага төгссөн болон энэ оноос өмнө бүрэн дунд боловсрол эзэмшсэн иргэн /цаашид өмнөх онд төгссөн шалгуулагч гэх/ өгнө.

Дөрөв. Шалгалтын бүртгэл

4.1 МХБШ болон ЭШ-ын бүртгэлийг www.eec.mn цахим хуудсаар дамжуулан БҮТ-өөс зарласан хугацаанд зохион байгуулна. Бүртгэлийн хугацааг сунгахгүй ба нэмэлт бүртгэл хийхгүй.

4.2 Монгол хэл, бичгийн болон Элсэлтийн шалгалтын бүртгэл 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 09.00 цагт эхэлж, 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 18.00 цагт хаагдана. Монгол хэл бичгийн шалгалтын бүртгэл 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 18:00 цагт хаагдана.

4.3 Шалгуулагч нь бүртгүүлэхдээ дараах зүйлсийг бэлдсэн байна. Үүнд:

4.3.1 Иргэний үнэмлэх болон түүнтэй адилтгах баримт бичиг /иргэний үнэмлэхийн лавлагаа, гадаад паспорт, цагдаагийн үнэмлэх, мөн гадаадын иргэний Монгол улсад оршин суух түр үнэмлэх/;

тамга даруулж баталгаажуулна. Харин өмнөх онд төгссөн шалгуулагчийн "бүртгэлийн хуудас" нь QR кодоор баталгаажсан байх ба шууд хэвлэн авна.

Тав. Шалгалтын хугацаа, зохион байгуулалт

МОНГОЛ ХЭЛ БИЧГИЙН ШАЛГАЛТЫН ХУВААРЬ

Сар/өдөр	Цаг	Шалгалт
04 дүгээр сарын 06 /Бямба гараг/	10:00-11:40	Монгол хэл бичгийн шалгалт

2024 ОНЫ ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТЫН ХУВААРЬ

Сар/өдөр	Цаг	Шалгалт
07 дугаар сарын 04 /Пүрэв/	10:00-11:20	Түүх
	13:00-14:20	Англи хэл
07 дугаар сарын 05 /Баасан/	10:00-11:40	Хими
	13:00-14:20	Газарзүй
07 дугаар сарын 06 /Бямба/	16:30-17:50	Нийгэм судлал
	10:00-11:20	Биологи
07 дугаар сарын 06 /Бямба/	13:00-14:40	Математик
	15:30-16:50	Орос хэл
07 дугаар сарын 07 /Ням/	10:00-11:40	Физик
	13:00-14:20	Монгол хэл

5.1 Аймаг, нийслэл (сум, дүүрэг)-ийн шалгалтын байранд БҮТ-өөс томилогдсон шалгалт зохион байгуулах комисс ажиллах ба батлагдсан удирдамжийн дагуу шалгалтыг зохион байгуулна.

5.2 Шалгуулагч өөрийн бүртгэлийн дугаар болон нууц үгийг ашиглан "суудлын хуваарь"-аа www.eec.mn, www.evesh.eec.mn цахим хуудасны "шалгуулагчийн булан"-аас хэвлэн авна.

5.3 Суудлын хуваарь хэвлэн авах хугацааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэх бөгөөд болон www.eec.mn, Боловсролын үнэлгээний төв гэсэн пэйж хуудас болон шалгуулагчийн и-мэйл хаягаар илгээнэ.

5.4 Тусгай орчин, нөхцөл, хэрэглэгдэхүүн шаардлагатай шалгуулагчийн ирүүлсэн өргөдөл, хүсэлт, эмчийн магадлагаа, сургуулийн тодорхойлолтод үндэслэн шалгалтын анги танхим, шалгалтын материалыг тусгайлан бэлтгэнэ.

5.5 Элсэлтийн шалгалт өгөхөөр ирэхдээ дараах материалыг заавал бүрдүүлж авчирна. Үүнд:

5.1.1 Бүртгэлийн хуудас

5.1.2 Суудлын хуваарь

5.1.3 Иргэний үнэмлэх болон түүнтэй адилтгах баримт бичиг /Иргэний үнэмлэх авах насанд хүрээгүй буюу 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хойш 16 насанд хүрэх шалгуулагч сурч буй сургуулийн захирал эсвэл өөрийн оршин сууж буй орон нутгийн Засаг даргын гарын үсэг, тамгаар баталгаажсан,

сүүлийн 3 сарын дотор авхуулсан өнгөт цээж зурагтай тодорхойлолт, төрсний гэрчилгээний хамт авч ирнэ.

5.1.4 Бүрэн дунд боловсролын үнэмлэх, түүнээс дээш боловсрол эзэмшсэнийг гэрчлэх баримт бичиг

5.6 Шалгуулагч шалгалтын байранд 60 минут, шалгалт өгөх анги танхимд 10 минутын өмнө суудлаа эзэлсэн байна. Дурдсан хугацаанаас хожимдсон шалгуулагчийг шалгалтад оруулахгүй.

5.7 Шалгалтын анги танхимд гар утас, тооны машин, таблиц, томьёоны хураангуй, ном, дэвтэр, ноорог цаас, гарын авлага, цаасан болон электрон толь бичиг, компьютер, таблет, ухаалаг цаг, дуу хураагуур, чихэвч зэрэг бусдад саад болох, хууран мэхлэх зорилготой ямар нэг зүйлийг авч орохыг хориглоно.

5.8 МХБШ болон ЭШ-ын математик, физик, химийн шалгалтын үргэлжлэх хугацаа 100 минут, монгол хэл, англи хэл, орос хэл, биологи, газарзүй, түүх, нийгэм судлал шалгалтын үргэлжлэх хугацаа 80 минут байна.

5.9 Хариултын хуудсыг санамжийн дагуу БҮТ-өөс тавьж олгосон балын харандаагаар тод засваргүй бөглөнө.

5.10 МХБШ-ын даалгаврыг хөх, цэнхэр өнгийн үзгэн болон тосон балаар гүйцэтгэнэ.

5.11 Элсэлтийн шалгалтын дэвтэр ба хариултын хуудас /цаашид шалгалтын материал гэх/-ыг тарааснаас хойш шалгалтын анги танхимд зөвшөөрөгдсөн эрх бүхий хүнээс бусад хүн орж, гарахыг хориглоно.

5.12 Шалгуулагч эрүүл мэндийн байдлаас болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар шалгалтын анги танхимаас гарсан бол шалгуулагчийн гарах хүртлээ хийсэн даалгаврыг дүгнэж зохих оноог өгнө.

5.13 Шалгуулагч хянагч багшийн зааврын дагуу баганаан кодыг наана. Шалгалт зохион байгуулах багийн гишүүд хариултын хуудсыг шалгуулагчдын өмнө тусгайлан бэлтгэсэн дугтуйд хийж битүүмжилнэ.

5.14 Шалгалтын материалыг БҮТ-д төвлөрүүлэн татаж, хадгална.

Зургаа. Шалгалтын засалт, үр дүнг мэдээлэх

6.1 Шалгалтын хугацаа дуусмагц, тусгайлан бэлтгэсэн шууд засалтын байранд тухайн шалгалтын хариултын хуудсыг засагч машинаар уншуулж, анхны оноог шууд мэдээлнэ.

6.2 Шалгалтын хэмжээст оноог тухайн шалгалтыг зохион байгуулснаас хойш 24 цагийн дотор www.eec.mn цахим хаягийн "шалгуулагчийн булан"-д байршуулна.

6.3 ЭШ-ын дүн онооны жагсаалтыг шалгалтыг зохион байгуулснаас хойш 24 цагийн дотор www.eec.mn цахим хуудсанд байршуулан нийтэд зарлана.

6.4 МХБШ-ын дүн оноог шалгалт зохион байгуулснаас хойш 10 хоногийн дотор www.eec.mn цахим хуудсанд байршуулан нийтэд зарлана.

6.5 МХБШ болон ЭШ-ын дүн оноо бүхий батламж хуудсыг www.eec.mn болон E-mongolia.mn цахим үйлчилгээний нэгдсэн порталд байршуулах ба дүн онооны жагсаалт зарласнаас хойш шалгуулагч өөрөө хэвлэж авна.

6.6 МХБШ болон ЭШ -ын батламж хуудас нь шалгалт өгснөөс хойш 2.8 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

6.7 Хүчинтэй хугацаа нь дуусгавар болсон батламж хуудас /дүнгийн тодорхойлолт/ нь их, дээд сургуульд элсэх үндэслэл болохгүй бөгөөд үүнтэй холбоотой хариуцлагыг БҮТ хүлээхгүй.

Долоо. Олон улсын шалгалтын үнэлгээг ЭШ-ын үнэлгээнд дүйцүүлэх

7.1 БШУЯ-ны сайдын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/66 тоот тушаалаар батлагдсан "Элсэлтийн шалгалтын журам"-ын 6.2-д заасны дагуу олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг шалгалтын үнэлгээг элсэлтийн шалгалтын үнэлгээнд дүйцүүлэх болон элсэлтийн шалгалтад хамрагдан аль өндөр үнэлэгдсэн үнэлгээгээрээ их, дээд сургуульд элсэн орно.

7.2 Олон улсын шалгалтын үнэлгээг ЭШ-ын үнэлгээнд дүйцүүлэхдээ сүүлийн 2 жилийн дотор олгогдсон олон улсын шалгалтын сертификат, дүнгийн хуудсыг үндэслэнэ.

7.3 Үнэлгээ дүйцүүлэх хүсэлтийг Элсэлтийн шалгалтын журмын 6.6.4-д заасны дагуу 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 13-ны өдрийг дуустал БҮТ-ийн www.eec.mn цахим хуудсаар хүлээн авна.

7.4 Үнэлгээ дүйцүүлэх хүсэлт хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 хоногт багтаан шийдвэрлэж, үнэлгээг дүйцүүлсэн "батламж хуудас"-ыг цахимаар олгоно.

7.5 Үнэлгээ дүйцүүлэх хүсэлтэй оюутан, суралцагч нь Олон улсын шалгалтын үнэлгээг Монгол Улсын ЭШ-ын үнэлгээнд дүйцүүлэх хүсэлт, холбогдох бичиг баримтыг БҮТ-ийн энэ удирдамжийн 7.3-д заасан цахим хуудасны "Элсэлтийн шалгалт"-гэсэн цэсээр ЭШ-д бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, нууц үгээ ашиглан нэвтэрч, ирүүлнэ. Үүнд:

7.5.1 Үнэлгээ дүйцүүлэх тухай хүсэлт.

7.5.2 Төрсний гэрчилгээ эсвэл иргэний үнэмлэхийн хуулбар.

7.5.3 Үнэлгээнд дүйцүүлэх хөтөлбөрийн сертификат, дүнгийн хуудасны хуулбар.

7.5.4 Бүрэн дунд боловсролын гэрчилгээний хуулбар эсвэл гадаадад бүрэн дунд боловсрол эзэмшсэнийг гэрчлэх дүйцүүлсэн баримтын хуулбар /зөвхөн өмнөх оны төгсөгч/.

7.5.5 Суралцаж буй сургуулийн тодорхойлолт /зөвхөн 12 дугаар ангийн суралцагч/.

7.6 Оюутан, суралцагч нь Олон улсын шалгалтын үнэлгээг Монгол Улсын ЭШ-ын үнэлгээнд дүйцүүлэх хүсэлтийн хариуг энэхүү удирдамжийн 7.5-д заасан цахим хаяг болон www.evesh.eec.mn цахим хуудасны "Дүйцүүлэх хүсэлтийн хариу" гэсэн хэсэгт нэвтрэн орж харна.

7.7 Оюутан, суралцагчдын дүйцүүлсэн оноог ЭШ-ын үндсэн жагсаалтад оруулахгүй ба харгалзах хичээлийн жагсаалтад онооны дагуу байршуулж тусад нь жагсаалт үүсгэн их, дээд боловсролын сургалтын байгууллагад хүргэнэ.

7.8 Оюутан, суралцагч нь дүйцүүлсэн онооны "Батламж хуудас"-аар Монгол Улсын их, дээд сургуульд элсэн суралцах эрхтэй.

7.9 Дүйцүүлсэн батламж хуудас нь олон улсын шалгалтад хамрагдаж, сертификат, гэрчилгээ авсан өдрөөс хойш 2 жилийн хугацаанд хүчинтэй байна.

7.10 Олон улсын шалгалтын үнэлгээг элсэлтийн ерөнхий шалгалтын үнэлгээнд дүйцүүлсэн тохиолдолд ЭШ-аас бусад зориулалтаар ашиглахыг хориглоно.

7.11 Гадаад болон дотоодын ерөнхий боловсролын сургууль төгссөн болон төгсөх ангид суралцаж байгаа, олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрдөг шалгалтын үнэлгээтэй Монгол улсын иргэн, оюутан, суралцагчид хамрагдана.

Найм. Өргөдөл, гомдол хүлээн авах, шийдвэрлэх

8.1 МХБШ болон ЭШ -ын явц, зохион байгуулалт, шалгалтын материал, дүн оноотой холбоотойгоор иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх 5-7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг БҮТ-ийн захирлын тушаалаар томилно.

8.2 БҮТ шалгалтын материал, дүн оноотой холбоотой өргөдлийг шалгалт зохион байгуулж дууссанаас хойш 5 өдөрт багтаан хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэнэ.

8.3 Бүртгэл болон шалгуулагчийн хувийн мэдээлэлтэй холбоотой өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг бүртгэлийн хугацаанд БҮТ-ийн 70119498 лавлах утас, info@eec.mn и-мэйл, <https://www.facebook.com/eec.mn/> цахим хуудсаар хүлээн авна. Мөн Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Оюутны гудамж-21, "Сантис" боловсролын төвийн байранд өөрийн биеэр, бичиг баримттайгаа ирж шийдвэрлүүлж болно.

8.4 Шалгалтын явц, зохион байгуулалттай холбоотой өргөдлийг бичгээр гаргаж, тухайн шалгалтын байранд томилогдон ажиллаж буй шалгалтын комисс асуудлыг шийдвэрлэнэ.

8.5 Шалгуулагч дүн оноотой холбоотой өргөдөл гаргасан тохиолдолд хариултын хуудсыг үндэслэл болгон шийдвэрлэнэ.

8.6 Шалгуулагчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зөрчилтэй холбоотой өргөдлийг хүлээн авч шийдвэрлэх боломжгүй бөгөөд шалтгаанаа тодорхой заагаагүй болон буцах хаяггүй өргөдлийг хүлээн авахгүй болно.

Ес. Шалгалтын дэг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

9.1 Бүртгүүлэхдээ бусдын данс, гүйлгээний картын мэдээллийг хууль бусаар ашиглан гүйлгээ хийсэн нь иргэний гомдлоор тогтоогдсон тохиолдолд тухайн шалгуулагчийг шалгалтад оруулахгүй.

9.2 Шалгалтын хугацаа (цаг, минут)-аас хоцорсон болон баримт бичгийн бүрдэл дутуу, хувийн мэдээлэл зөрүүтэй шалгуулагчийг шалгалтад оруулахгүй.

9.3 Шалгуулагч шалгалтын даалгаврыг гүйцэтгэхдээ бусдаас дэмжлэг авсан, хориглосон зүйлийг ашигласан, бусдад тусалсан, бусдаас тусламж авсан, хоорондоо ярилцах зэргээр бусдад саад учруулсан бол шалгалтын дэг зөрчсөнд тооцож, тухайн шалгалтын материалыг хүчингүй болгоно.

9.4 Шалгалтад өөрийнхөө оронд хүн оруулсан, бичиг баримтыг хуурамчаар үйлдэн хууран мэхлэхийг завдсан тохиолдолд тухайн шалгуулагчийн бүх шалгалтын дүн оноог хүчингүй болгоно.

9.5 Иргэн, хуулийн этгээд нь шалгуулагчийг хууль бус үйлдэл гаргахад дэмжлэг үзүүлсэн, үгсэн хуйвалдсан, нуун дарагдуулсан эсвэл шалгалтын бэлтгэл болон явц, дүн оноотой холбоотой санаатай болон санамсаргүй болон санаатай

үйлдлээр, хэвлэл мэдээлэл, цахим сүлжээгээр худал мэдээлэл тарааж байгууллагын нэр хүнд, хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан бол цагдаагийн байгууллагад шилжүүлэн шалгуулж хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

9.6 Шалгалтад ороход шаардлагатай болон шалгалтын дүн оноотой холбоотой бичиг баримтыг шалгуулагч хуурамчаар үйлдсэн нь нотлогдсон тохиолдолд холбогдох хуулийн байгууллагад хандан хариуцлага хүлээлгэнэ.

Арав. Бусад

10.1 БҮТ нь зохион байгуулсан шалгалтын дүн, оноо, тайлан, үр дүнг олон нийт, боловсролын байгууллага, судлаачдад www.eec.mn, www.stat.eec.mn цахим системээр болон хэвлэмэл байдлаар хүргэх ба дүн оноог блокчейн сүлжээнд байршуулна.

10.2 Шалгалтын үр дүнгийн талаарх мэдээлэл авах хүсэлтээ тухайн байгууллага албан бичгээр БҮТ-д ирүүлнэ, БҮТ нь бүх шатны боловсролын болон судалгаа шинжилгээний байгууллагад шалгуулагчдын статистик дүн мэдээ, шалгалтын хичээл тус бүрийн дунджаар дүн оноог гаргаж өгч болно.

10.3 Шалгалтын талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон "Элсэгчийн сонин", www.eec.mn, <https://www.facebook.com/eec.mn/>, гар утасны EEC аппликэйшн, page хуудас, stat.eec.mn, help.eec.mn цахим хуудас, шалгуулагчийн бүртгүүлсэн и-мэйл хаягаар хүргэнэ.

10.4 МХБШ болон ЭШ-ын сэдэв даалгавар бэлтгэх, хувилах, хүргүүлэх, шалгалтын материалыг төвлөрүүлэн татах, засах, үнэлэхтэй холбоотой нууцлалыг БҮТ хариуцна.

10.5 Байгалийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас БҮТ-ийн захирлын тушаалаар удирдамжид нэмэлт өөрчлөлт оруулж болно.

---000---

ОЛОН УЛСЫН ШАЛГАЛТЫН ҮНЭЛГЭЭГ ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТЫН ҮНЭЛГЭЭТЭЙ ДҮЙЦҮҮЛЭХ ЦАХИМ ХҮСЭЛТ АВЧ ЭХЭЛЛЭЭ

БШУ-ны сайдын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/66 тоот тушаалаар батлагдсан "Элсэлтийн шалгалтын журам"-ын **ЗУРГААДУГААР** бүлэгт заасны дагуу улс орнуудад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг олон улсын шалгалтын үнэлгээг Монгол Улсын их, дээд сургуульд оюутан элсүүлэх "Элсэлтийн шалгалт"-ын үнэлгээтэй дүйцүүлнэ.

ҮҮНД:

- ⇨ Кембрижийн AS, A,
- ⇨ IB- International Baccalaureate
- ⇨ TOEFL/IBT/
- ⇨ PTE
- ⇨ IELTS
- ⇨ SAT

⇨ Их, дээд сургуулийн элсэлтийн шалгалт нь төгсөлтийн шалгалттай нэгдмэл зохион байгуулагддаг гадаадын ахлах сургууль төгссөн болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бусад хөтөлбөрөөр суралцаж төгссөн оюутан, суралцагчдын сурлагын дүн, оноог дүйцүүлнэ.

ОЮУТАН, СУРАЛЦАГЧ-ЦАХИМ ХҮСЭЛТ ИЛГЭЭХ

Олон улсын шалгалтын үнэлгээг Монгол улсын ЭШ-ын үнэлгээнд дүйцүүлэх хүсэлт, холбогдох бичиг баримтыг тухайн жилийн ЭШ эхлэхээс хамгийн багадаа ажлын 15 хоногийн өмнө Боловсролын үнэлгээний төвийн www.eec.mn сайтад орж "Элсэлтийн шалгалт" гэсэн цэсийг дарж **"ДҮЙЦҮҮЛЭХ"** гэсэн сонголтыг хийж, ЭШ-д бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, нууц үгээ ашиглан системд нэвтэрч холбогдох мэдээлэл болон материалаа зааврын дагуу оруулан хүсэлтээ цахимаар ирүүлнэ.

Хүсэлт ирүүлэхэд оюутан, суралцагчийн бүрдүүлэх материал. Үүнд:

- ⇨ Үнэлгээ дүйцүүлэх тухай хүсэлт
- ⇨ Төрсний гэрчилгээ эсвэл иргэний үнэмлэхийн хуулбар
- ⇨ Үнэлгээнд дүйцүүлэх хөтөлбөрийн сертификат буюу дүнгийн хуудсын хуулбар
- ⇨ Бүрэн дунд боловсролын гэрчилгээний


хуулбар эсвэл гадаадад бүрэн дунд боловсрол эзэмшсэнийг гэрчлэх дүйцүүлсэн баримт /өмнөх оны төгсөгчийн хувьд/

- ⇨ Суралцаж буй сургуулийн тодорхойлолт /12 дугаар ангийн суралцагчийн хувьд/

Боловсролын үнэлгээний төв нь хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 хоногт багтаан шийдвэрлэнэ. Оюутан, суралцагч нь хүсэлтийн хариуг дараах 2 замаар харна. **Үүнд:**

- www.eec.mn сайтын "Элсэлтийн шалгалт" гэсэн цэсийн "Дүйцүүлэх" гэсэн хэсэгт элсэлтийн шалгалтад бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, нууц үгээ ашиглан нэвтэрч харах /дэлгэрэнгүй хариу харах боломжтой/
- <https://eyesh.eec.mn/> цахим хаягаар "Дүйцүүлэх хүсэлтийн хариу" гэсэн цэсийг сонгож регистрийн дугаараараа нэвтэрч харна.

Мэдээлэл бэлтгэсэн:
БҮТ-ийн мэргэжилтэн Р.Ундрахбаяр



ОЛОН УЛСЫН ШАЛГАЛТЫН ҮНЭЛГЭЭГ ДҮЙЦҮҮЛЭХ ЦАХИМ ХҮСЭЛТ ХҮЛЭЭН АВАХ ХУГАЦАА


2024.03.01-НИЙ 09:00 ЦАГААС ЭХЛЭН
2024.06.13-НЫ ӨДРИЙН 18:00 ЦАГ

ХҮРТЭЛ ХҮЛЭЭН АВНА.

ТАЙЛАР:
Боловсролын үнэлгээний төвийн www.eec.mn цахим хаягаар орж Элсэлтийн шалгалт цэсийн "Оюутан шалгалтын үнэлгээ дүйцүүлэх" гэсэн хэсэгт бүртгэлийн дугаар, нууц үгээ ашиглан нэвтэрч илгээх юу.

БЭБ САЙТ WWW.EEC.MN ДАВЛАХ УТАС 7011 9498

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ - 2024



ОЛОН УЛСЫН ШАЛГАЛТЫН ДҮН, ОНООГ ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТЫН ДҮН, ОНООТой ДҮЙЦҮҮЛЭХ ЦАХИМ ХҮСЭЛТ ИЛГЭЭХ АЛХАМ

АЛХАМ 1 АЛХАМ 2 АЛХАМ 3 АЛХАМ 4 АЛХАМ 5 АЛХАМ 6 АЛХАМ 7 АЛХАМ 8 АЛХАМ 9 АЛХАМ 10

БЭБ САЙТ WWW.EEC.MN ДАВЛАХ УТАС 7011 9498

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ - 2024



ОЛОН УЛСЫН ШАЛГАЛТЫН ҮНЭЛГЭЭ ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТЫН ҮНЭЛГЭЭТЭЙ ДҮЙЦҮҮЛЭХ ХҮСЭЛТИЙН ХАРИУ ОЮУТАН, СУРАЛЦАГЧ НЬ


01 www.eec.mn сайтын Элсэлтийн шалгалт цэсийн "Оюутан шалгалтын үнэлгээ дүйцүүлэх" хэсэгт элсэлтийн шалгалтад бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, нууц үгээ ашиглан нэвтэрч дэлгэрэнгүй харах.

02 [www.eyesh.eec.mn/](https://eyesh.eec.mn/) цахим хаягийн "Дүйцүүлэх хүсэлтийн хариу" гэсэн цэсийг сонгож регистрийн дугаараар оруулан нэвтэрч харах.

1 Оюуныг оролдогчидын дүн оноо дүйцүүлэх хүсэлтийг заримт хүсэлт ирүүлсэн өдөр эхлэх 10 хоногт багтаан шийдвэрлэнэ.

БЭБ САЙТ WWW.EEC.MN ДАВЛАХ УТАС 7011 9498

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ - 2024



Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
Боловсролын үнэлгээний төв

CallPro
Unified Communication Company

БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВИЙН ХАРИЛЦАХ УТАС

7011 9498

ДАВАА-БААСАН 08³⁰-17³⁰

БЭБ САЙТ WWW.EEC.MN ДАВЛАХ УТАС 7011 9498

CAREER COACHING

АХЛАХ АНГИЙН СУРАГЧДАД ЗОРИУЛСАН МЭРГЭЖЛЭЭ СОНГОХОД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

МУИС-ийн Ажил мэргэжил судлал хөтөлбөрөөс мэргэжил сонголтод нөлөөлж буй хүчин зүйлс, тулгарч буй бэрхшээлийг тодорхойлох судалгааг 2018-2019 онд хийсэн. ЕБС-ийн сурагчид өөрийн сонирхол, авьяас чадварт нийцсэн байдал, ирээдүйтэй ажил мэргэжил зэргийг мэргэжил сонголтод харгалздаг болох нь тус судалгаанаас харагдсан. Мэргэжлийн чиг баримжаатай холбоотой онолуудад мэргэжил, ажил нь тухайн хүний сонирхол, чадварт нийцсэн байдлыг чухлаар авч үздэг.

Энэ нийтлэлээр ахлах ангийн сурагчдад мэргэжлээ сонгоход чиглүүлэх хэдэн асуултыг хүргэж байна. Мэргэжлээ сонгосон, сонгоогүй бүх сурагчдаас доорх асуултуудад тухтай суугаад хариулахыг хүсье. Хэдийнээ мэргэжлээ сонгосон сурагчдын хувьд эдгээр асуултууд сонголтдоо нягтлах шалгуур болох юм. Харин хараахан сонгоогүй байгаа сурагчдад мэргэжлээ сонгоход туслах чиглүүлэг болно.

Үүнд:

- 1 Тухайн мэргэжил, ажлын байрны үүрэг сонирхолд чинь нийцэж байна уу?
- 2 Тухайн мэргэжил, ажлын өдөр тутмын үйл ажиллагааг сайн чиглүүлж чадах уу?
- 3 Тухайн мэргэжил, ажил чиний зан төлөвт нийцэх үү?
- 4 Тухайн мэргэжил, ажлын өдөр тутмын үйл ажиллагаа, үр дүн нь чиний амьдралын болон ажлын үнэт зүйлсэд нийцэх үү?
- 5 Тухайн мэргэжил, ажлаас чи юу хүлээж байна вэ?
- 6 Тухайн мэргэжлийн ажлын байрны эрэлт, хөрвөх чадвар хэр вэ?
- 7 Тухайн мэргэжлийг эзэмшээд мэргэжлээрээ ажиллаж байгаа хүмүүстэй ярилцсан уу?

1 Сонирхол хэдийгээр өөрчлөгдөж байдаг хэдий ч мэргэжлээ сонгохдоо заавал харгалзах хэрэгтэй. Гол нь шийдвэр гаргахаасаа өмнө өөрийнхөө сонирхолын тухай эрэгцүүлэн бодоорой. Би юу, юу хийх дуртай вэ? Надад ямар хичээлүүд сонирхолтой байдаг вэ? Яагаад эдгээрийг би хийх дуртай вэ? Чухам юу нь надад нь сайхан санагддаг вэ? гээд өөрөөсөө асуух хэрэгтэй. Тэгээд хариултаа тэмдэглээд ав. Эдгээр асуултын хариултаас мэргэжил сонгохдоо сонирхолд чинь нийцэж байгаа эсэхийг шалгах шалгуураа харж болно. Жишээ нь: "Би математикийн хичээлдээ дуртай. Математикийн даалгавраа хийх, бодлого бодохдоо зөв хариу гарах үед баярладаг. Би яг кинон дээр гардаг асуудлын шийдлийг олж байгаа мөрдөгч шиг санагддаг" гэж бичлээ гэхэд асуудлыг шийдвэрлэх, бас чамд өөрийгөө сорих боломж олгодог ажил чиний сонирхолд нийцнэ гэж хэлж болно.

2 Чадварт чинь нийцсэн байх тухай бодохдоо дараах хоёр талаас бодох хэрэгтэй. Эхнийх нь мэдээж чиний сайн чаддаг зүйлийг хийдэг мэргэжил байвал чи урам зоригтойгоор ажиллаж чадна. Харин сайн чадахгүй боловч чиний үнэхээр хүсч байгаа мэргэжил мөн бол чадвараа хаана, хэрхэн, хэний тусламжтайгаар сайжруулж болох вэ? гэдэг асуултыг өөртөө тавих ёстой юм шүү.

3 Зан төлөвт чинь нийцсэн эсэхийг ч мөн хоёр талаас нь бодоорой. Хэрэв чи хүмүүстэй харилцахаас зайлсхийдэг, тайван хүн бол олон хүнтэй ажилладаг ажил тийм ч тохиромжтой биш байж болно. Нөгөө талаас хүний зан төлөв эрхэлж буй ажил мэргэжлээсээ шалтгаалаад аажмаар өөрчлөгддөг тал бий. Урт хугацаанд нэг ажлаа эрхлээд ирэхээр нягтлан хүмүүс аливаа алдааг амархан харчихдаг, багш хүмүүс хүнийг нэг хараад л ямар хүн болохыг танидаг болдог. Тиймээс би ямар онцлогтой хүн билээ? Миний эзэмшихийг хүсч буй мэргэжилд шаардагдах ажилтны хандлага, онцлогийг би өөртөө төлөвшүүлж болох уу? гэдгийг бодож үзээрэй.

4 Амьдрал, ажилдаа эрхэмлэдэг үнэт зүйлсээ жагсаагаад тэдгээр үнэт зүйлстэй тухайн мэргэжлийн үйл ажиллагаа, ажлын үүрэг нийцэж буй эсэхийг шалгаарай. Жишээ нь: Итгэл үнэмшлийн хувьд чи бүх амьтны амь үнэ цэнэтэй гэж хатуу итгэдэг бол биологи, анагаахын салбарт суралцах, ажиллахад хүндрэл гарч болзошгүй. Ажлын үнэт зүйлсээ тодорхойлоход чинь туслах зорилгоор МУИС-ийн Ажил мэргэжил судлалын хөтөлбөрийн багт ажилладаг сэтгэл судлаач багш нарын боловсруулсан Мэргэжлийн үнэт зүйлсийн жагсаалтыг та бүхэнд хүргэж байна.

Заавар: Доорх 10 үнэт зүйлийг уншаад өөрт хамгийн чухлаас эхлүүлэн эрэмбэлээрэй.

1	Бусдад туслах - Хүнд туслах, хэн нэгний төлөө сайн үйлс бүтээхийг өөрийн амьдралын хамгийн чухал зүйл гэж боддог.
2	Тогтвортой ажлын байр - Ажлаас халагдах эрсдэл багатай, тогтвортой орлогыг чухалд үздэг.
3	Өсч хөгжих боломж - Нэгэн хэвийн үйл ажиллагаанаас зайлсхийдэг ба шинэ зүйлийг эрэлхийлж, өөрийн чадварыг нэмэгдүүлэхийг чухалд үздэг.
4	Өндөр орлогын боломж - Өөрийн суурь хэрэгцээгээ хангах, хадгаламжтай болох, хүссэн зүйлээ худалдаж авах боломжтой байхыг чухал гэж үздэг.
5	Цагийн уян хатан байдал - Илүү цагаар ажиллаж шаардлагагүй, ажлын цагийг өөрөө зохицуулах боломжтой байдлыг чухалчилдаг.
6	Бусадтай хамтран ажиллах - Олон хүнтэй танилцдаг, багаар ажиллах боломжтой, олуулаа нэг оффист хамт суухыг чухалчилдаг.
7	Бие даан ажиллах - Цөөн хүмүүстэй ажилладаг, бусдаас хамааралгүй өөрийн үүрэг даалгавраа биелүүлэх боломжтой байхыг чухалчилдаг.
8	Бүтээлчээр ажиллах - Аливаа зүйлийг олон талаас харах, шинэ гаргалгаа олох, урлагийн мэдрэмжтэй байхыг чухалд үздэг.
9	Техник технологийг ашиглах - Техник хэрэгслийг задлах, бүтээх, ашиглахыг илүүд үздэг.

10 Бусдад үнэлэгдэх - Мэргэжлийн нэр хүнд, бусдад хүлээн зөвшөөрөгдөх байдлыг илүүд үздэг.

Дээрх үнэт зүйлсийг эрэмбэлэж дууссан бол эхний 1, 2, 3 дугаарт эрэмбэлсэн үнэт зүйлсээ тодруулах эсвэл тэмдэглэж аваарай. Дараа нь чиний сонирхож буй мэргэжил эдгээр 3 үнэт зүйлд нийцэж байгаа эсэхийг нягтлаарай. Сонирхож буй мэргэжил чинь үнэт зүйлсэд тань нийцэж байвал чи мэргэжилдээ сэтгэл ханамжтай, хийж байгаа зүйл чинь утга учиртай байх боломжтой.

5 Ирээдүйн амьдралын хүлээлтэд чинь тухайн мэргэжлийг эзэмшсэнээр хүрч чадах эсэхээ бас бодож үзэх хэрэгтэй. Эхлээд энэ мэргэжлийг эзэмшсэнээр би хүсч буй амьдралаа бодитой болгож чадах уу? гэдэг асуултад хариулаарай. Үүний тулд чи ирээдүйд хаана, хэрхэн амьдрахыг хүсч байгаагаа мэдэж байх шаардлагатай. Хэрэв сонирхож буй мэргэжил чинь ирээдүйн хүлээлтийг чинь биелүүлэхээргүй байвал нөгөө талаас нь бодоод үзээрэй. Тодруулбал, сонирхож буй мэргэжлээ эзэмшээд, сурсан ур чадвараа хэрхэн ашиглавал би хүсч байгаа амьдралаа бүтээж чадах вэ? гэдэг асуултыг өөртөө тавина гэсэн үг юм. Учир нь ямар ч мэргэжлийг сайн эзэмшээд, түүнийгээ хэрхэн ашиглах арга олж чадвал хүсч буй амьдралаа бүтээж чадна.

6 Хөдөлмөрийн зах зээлийг судлахдаа мэдээж ирээдүйд ажлын байр хангалттай байх уу гэдгийг бодож үзнэ. Нөгөө талаас энэ мэргэжлийг эзэмшвэл ажлын байр багатай ч мэдлэг, чадвараа ашиглан өөр ажлын байранд хөрвөх боломжтой юу гэдэг асуултын хариултыг олоорой.

7 Аливаа ажлын ямар чадвар, хандлага шаарддаг болох, өдөр тутамдаа ямар үйл ажиллагаа эрхэлж, ямар үр дүнг бүтээдэг болох, чиний ажил мэргэжлээс хүсч буй хүлээлтийг биелүүлж чадах эсэхийг хэлж өгч чадах хүн бол тухайн мэргэжлийг эзэмшээд, эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаж буй мэргэжилтэн юм. Тиймээс ийм мэргэжилтэнтэй уулзаж ярилцах нь шийдвэр гаргахад чухал түлхэц болно.

Эцэст нь хэлэхэд мэргэжлээ сонгох гэдэг амьдралын чухал шийдвэр гарцаагүй мөн. Гэхдээ дэлхий дахинд хүн амын дундаж наслалт нэмэгдэж байгаатай холбоотойгоор хүн амьдралдаа нэг мэргэжил эзэмшээд тэрийгээ насан туршдаа эрхэлж амьдрах тухай ойлголт өөрчлөгдөж эхэлж байна. Тиймээс "Мэргэжлээ сонгохдоо алдаа гаргах вий" гэж хэтэрхий их айх хэрэггүй. Дээрх долоон асуултаар сонголтдоо нягтлахад л болно. Хэрэв бие даан дээрх зүйлсийг тунгаан бодоход хүндрэлтэй байгаа бол ажил мэргэжлийн зөвлөх эсвэл сургуулийнхаа сэтгэл зүйчид хандаарай.

Мэдээлэл бэлтгэсэн: Н.Должин (Магистр)
МУИС-ийн Ажил мэргэжил судлалын хөтөлбөр



НЭГДҮГЭЭР ХЭСЭГ - [20 ОНОО]

САНАМЖ:

- Эхийг анхааралтай уншин асуул даалгавар бүрийг гүйцэтгээрэй.
- Сонгож авсан үг, өгүүлбэрийг эхийн утга санаатай холбож ажиллаарай.
- Сонгох даалгавраас зөвхөн нэгийг дугуйлаарай.
- Даалгавар бүр 2 оноотой.

УСАНД ЯВАХАД

Өвлийн өдөр нар хэлбийж байлаа. Нар цаст Жаргалантын тэргүүн дээр төө хэрийн зайтай болоршин гялалзаж харагдана. Мөдхөн нөгөө охин усанд явна. Би ч бас.

Гэхдээ тэр эхэлж, ногоон даамангийнхаа хаалгыг нэг гараараа түлхэн нээгээд, нөгөө гартаа хоёр хувингаа зэрэгцүүлэн барихад харшиж хангинасан дуу гарна. Тэдний даамангийн хаалга нээгдэхэд миний сэтгэлийн хуудсыг чичирхийлэн эргүүлэх шиг болдог юм. Хувингууд нь харшиж дуугарахдаа "Би усандаа явлаа шүү" гэж надад хэлдэг. "Тэр одоохон гараад ирнэ дээ" гэж бодохоор зүрхэн тушаа түг түг цохилно. Зүрх минь догдлохын тоогоор миний дурлалын алтан үсэг сэтгэлийн дэвтэрт цохигдох бөгөөд энэ л үед би ирээдүйн зүйрлэшгүй сайхныг зөгнөхдөө огторгуй сансарт гардаг болчихоод удаж байгаа.

Гэтэл... гэтэл өнөө охины хувингаа хавируулах танил дуун цонхон дээр хүйтэн мөс тавьсан мэт цочоон сэрээв. Шалавхийн өнгийж харвал тэр минь сэтгэлд зураастай байдаг тийм л хонгорхон үзэмжит үйл төрхөөрөө хашаанаасаа гарч, урд голыг чиглэн алхаж байлаа. Би ч чавхнаас алдуурсан чулуу мэт ухасхийн гэрээсээ гарч түүнийхээ араас дагав. Бэлдэж дэргэдээ тавьсан бээлийгээ мартаж орхисноо ч сэхээрсэнгүй. Тэр маань өвлийн дэглий шиг хөнгөн салхи татуулан алхаж явсаар гилтийн хөлдсөн голын мөсөн дээгүүр цаашилж байлаа. Цааханд нь харзалсан усны толио мэлмэрэн мэлмэрэх нь түүний минь нүд шиг харагдана. Харзаас хальсан ус голын толигор мандал дээгүүр уйлагнан тархаж, тэр дороо л мөс болон хөлдөнө. Цэв цэнхэр мөстэй, цэв цэнгэг жавартай, цэв цэнхэрхэн үдэш ажээ.

Охин усан халиаг зайчлан гишгэхдээ хоёр гартаа барьсан мөнгөлөг хувингаа хойш урагш сэлүүлэн даялах нь улам ч харах сэтгэлийг төрүүлэх үзэмжтэй болов ч, би ч бас өөрөө уначихгүйг хичээн дүүжигнэх тул санаан зоргоор харц нисгэж чадахгүй байлаа. Тийнхүү түүнийг харж чадахгүй байгааг эзгүйчилсэн ч юм шиг эсвэл миний л харц номин дээлтийгээ түшиж явсан юм шиг энэхэн хооронд тэр гилтгэр торгон мөснөө унаж үзэгдэв. Хоёр хувин нь адтайгаар тохуурхан хөхрөх мэт жин жин дуу хадаан бөмбөрч харагдана. Өрөөсөн гутал нь улаараа мөсөнд наалдсанаас сугарч хоцроод, өнөө "дэглий" минь уначихсан чигтээ гутлаа авах гээд хүчлэн татаж байлаа. Өөр хэн нэгнийг ийнхүү хөглөхийг би харсан сан бол саяын тохуутай жингэнэж одсон хувин шиг элэглэн хөхрөх байсан. Гэвч энэ удаад яахан тэгнэ. Харин ч өрөвдөх шимшрэх сэтгэл намайг голын хүйтэн жаврыг үл хайхруулан халууцуулж байгааг мэдэрлээ. Тэгээд сэтгэл минь "Юугаа бодсон юм, түргэн түүнд туслаач" гэж тархинд хашхирахад хоёр саваа хаяад

мөсний халиа усыг үсчүүлэн охин дээр дэгдэж хүрэв. Намайг дэргэд нь очиход тэр мөстэй барьцалдсан гутлаасаа нэхмэл цагаан оймсоо шалавхийн авч өмслөө. Яг энэхэн мөчид надад толгой зулайнаас эхлэн хөлийн үзүүрийг чимчиртэл нэгэн соньхон долгио бүх биеийг тархан эзэмдэхүйд хацар хагарах гэж байгаа мэт халуу шарав. Ингэж халуу шатах нь хүйтэн жаварт ягаарч улайсан уран шөмбөн хөлийг цагаан оймсонд зурсхийн шургуулснаас тэр. Охин танхилын хөлийг хором эгшинд харахын төдийд тийм гайхам мэдрэмж төрдгийг балчир жулдрайхан хөвгүүн би яаж ч мэдэх билээ дээ. Яах гэж тэнд очсоноо ч мартаж шиг болов. Надад мөснөөс гутлыг салгахад баахан хүч шаардсангүй. Ховх татан авч өглөө. Хоёр гар минь ер бусын хүндтэй зүйл хийсэн мэт санагдана. Ингэхэд тэр зэрмэгэр хар нүдээрээ над руу тогтуухан харж, нүдэндээ үл ялиг инээмсэглэл тодруулаад нэг юм хэлэх гэснээ болив бололтой уруулаа жимийн цааш огцом эргэн хэд алхаад усаа уудалж эхэллээ. Би түүний хажууханд суугаад усаа уудаллаа. Тэр зөвхөн ус уудлахдаа л бүх санаа бодлоо шингээсэн мэт. Сормуус нь үзүүрээсээ цантан цайрч дэргийгээд голын зэрлэг жаварт энхрийхэн цагаан шаргал царай нь яв ягаан болчихсон нь ер бусын хөөрхөн.

Баруун хацрын үзэгдэх төдий жижигхэн хар мэнгэ, цэвэрхэн шөнтгөр хамар, үл мэдэг нууц давхраатай алаг нүд, тэгшхэн хоёр мөр тэргүүтэн бүгд нэгэн дор гоо үзэсгэлэнг бүрдүүлжээ. Харзны мөсөн эрэгт хатуу өвлөөр дэлбээлсэн хаш цэцэг адил солонготой ажээ.

Гэнэт тэр:

"Усаа асгалгүй уудлаач!" гээд инээмсэглэлээ нууж ядан харахад нь өөрийгөө ямархуу байдалтайгаа мэдлээ. Би шанага усныхаа талыг нь хувин руугаа, талыг нь гадуур асгаад байсан байж. Ус уудлахын дүр байдалтай суув чиг ухаан бодол маань чухамхүү үзэсгэлэнгийн өмнө бүхнийг мартагнан сатаарчээ. Өвлийн богино үдэш бараантан нөмөрч, гэгээ бөхөөд, голын мөс хүйтнээр жингэнэн тачигнаж эхэллээ. Энэ жингэнэнд даарсандаа юу, угаас турьгүй нарийхан бие нь сөхөрчөхөө үү, тэр маань дахиад голын цэнхэр толион дээр тэнцвэр алдан өвдөглүүтээ босож ирэв. Энэ л мөчийг хүлээж байсан мэт уйгагүй мөшгөн дэгдэгч би өөрийн савтай усаа орхин түүнийхээ хоёр хувинтайг явуутаа шүүрээд мөсний захад гаргалаа. Тэр юу ч үл дуугаран араас минь алхаж байгааг мэдэрч байв. Түүний хацар тоорын адил ув улаан болжээ. Норж хөлдсөн дээлийн хормой хөлдөөд дарр дарр хийнэ. Хоёр цагаан нэхий бээлий нь зүгээр л мод шиг унжжээ. Түүрүүнээс хойш түүнийг өрөвдөж энхрийлсээр атал ерөөс түүнийг шоглож дооглох бодол хэзээ ч төрдөггүй байтал энэ удаа хаанаас ч юм гайтай хар инээд гарч ирээд түсхийлэгдэг байна шүү. Ээ, бүү үзэгд гэж. Хяссан юм шиг ийм зүйл гэнэт бас болдог байжээ. Утга учиргүй инээж чиггүй тэнэглэсэн тэр дороо л би мэдлээ. Ямар ч хэрэггүй үед ингэж алмайран инээж хамаг сайн сайхныгаа балласан өөрийгөө зүхэхэд хожимджээ.

Нэгдлийн тэжээлийн байрыг тойроод хувинтай ус, хөлдүү хормой хоёроо шаргиулан харшуулсаар тэр маань далд орлоо. Би түүнийг насан үүрд гомдоочихсон юм шиг дахиад ер

хэзээ ч дагаж явахгүй болчихсон мэт бодогдоход юутай ч зүйрлэмгүй зовлонд дарагдав. Алхам газар ч хорогдохгүй байгаа юм шиг санагдаж яван явсаар тэжээлийн хашааг тойрч түүнд ил гарч ирэв. Өвлийн шөнө эхлэхийн өмнөх бүдэг бадаг гэгээнд хашааныхаа хаалганы өмнө зогсож байгаа нь танигдлаа. Надаас нэгмөсөн нүүр буруулчихсан бол ингэж зогсохгүй нь мэдээж санагдахаар дахиж хэзээ ч, бүр юунд ч инээхгүй юм шүү гэж шүд зуулаа. Агшин бүрээр харанхуй болж байлаа. Тэр хашаа руугаа орохгүй л байв. Би хөдөлгөөнгүй харан зогсоор л. Саахалтын зайтай тэндээс түүний хөөрхөн мишээл надад гэрэлтэн харагдсаар. Тэр мишээлийг би нүднээсээ илүү сэтгэлдээ тод харж байв. Саяхны ээдрээ гуниг юу ч үгүй алга болж, би тэнгэрт хөөрөхөд бэлэн хөвсөлзжээ. Нэгдлийн даргын шар тэрэг сумаар нэг гэрлээ шилбүүрдэн тэднийхийг чиглэхэд тэр минь над руу энэ орой эцсийн удаа гэрэлтэн хараад хашаа руугаа орчхов. Миний дотор баяр баясгалангаар дүүрч бялхжээ. Түүнийг надаас нуусан ногоон дааман машины гэрэлд тодрохыг цоо ширтсэн чигтээ хоёр савтай усаа аван "Ура" хашхиран хүчтэй алхтал урд хормойноос нэг юм татчих шиг болоод, тэр мөртөө урагш тонгорцоглон уналаа. Гэгээн догдлолт энэ л сайхан хормуудад би зөвхөн түүнийгээ харж зогсохдоо хувинтай усандаа хормойгоо дүрээд хөлдөөчихсөн байжээ. Намайг тойрон хавиар нэлийн асарсан ус агшин зуур мөстөн хөлдөхдөө тэнгэрийн од эрхсийг шигтгэн гэрэлтүүлж гялбалзуулахад, гар минь тэсэхийн аргагүйгээр даарч байгааг сая л мэдлээ. /Б.Золбаяр/

1. Эхэд орсон дараах үгсийн утгын тайлбарыг зөв харгалзуулсан хэсгийг олоорой.

1.харз	а. мөсний дээгүүр урссан ус
2.халиа	б. толийж харагдах
3.цан	с.голын хөвөөнд, өнгийж тогтсон ирмэг
4.толио	д.хүйтэнд үл хөлдөх ус
5.эрэг	е. царцаж тогтсон цас мэт зүйл

- A. 1a,2d,3b,4e,5c
B. 1d,2c,3a,4b,5e
C. 1a,2d,3b,4e,5c
D. 1d,2a,3b,4e, 5c
E. 1d,2a,3e,4b, 5c

2. Хүүг юу цочоон сэрээсэн бэ?

- A. Тэр одоохон гараад ирнэ дээ гэж бодохоор түг түг цохилох зүрх
B. Охины хувингаа хавируулах танил дуун
C. Сэтгэлд зураастай байдаг хонгорхон үзэмжит үйл төрх
D. Даамангийн хаалга нээгдэх үе
E. Болоршин гялалзах нар


3. "Толгой зулайнаас эхлэн хөлийн үзүүрийг чимчиртэл нэгэн соньхон долгио бүх биеийг тархан эзэмдэхүйд хацар хагарах гэж байгаа мэт халуу шарсан" шалтгаан нь юу вэ?

- A. Уран шөмбөн хөлийг цагаан оймсонд зурсхийн шургуулснаас
B. Тэр гилтгэр торгон мөснөө унаснаас
C. хатуу өвлөөр дэлбээлсэн хаш цэцэг адил солонготой харагдсанаас
D. "дэглий" минь уначихсан чигтээ гутлаа авах гээд хүчлэн татсанаас

- Е. Тэр зэрмэгэр хар нүдээрээ над руу тогтуухан харснаас
4. Эхэд дэвшүүлсэн асуудал буюу сэдвийг тодорхойлоорой.
- A. Усанд явсан тухай
 - B. Бага насны харууслын тухай
 - C. Өвлийн хүйтний тухай
 - D. Анхны хайрын тухай
 - E. Бага насны ухаарлын тухай
5. Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой.
- A. Харзаас хальсан ус голын толигор мандал дээгүүр уйлагнан тархаж, тэр дороо л мөс болон хөлдөнө.
 - B. Намайг тойрон хавиар нэлийн асгарсан ус агшин зуур мөстөн хөлдөхдөө тэнгэрийн од эрхсийг шигтгэн гэрэлтүүлж гялбалзуулна.
 - C. Нэгдлийн тэжээлийн байрыг тойроод хувинтай ус, хөлдүү хормой хоёроо шаргиулан харшуулсаар тэр маань далд орлоо.
 - D. Цэв цэнхэр мөстэй, цэв цэнгэг жавартай, цэв цэнхэрхэн үдэш ажээ.
 - E. Тэдний даамангийн хаалга нээгдэхэд миний сэтгэлийн хуудсыг

- чичирхийлэн эргүүлэх шиг болдог юм.
6. Би баатрын ээдрээ гунигийг юу арилгасан бэ?
- A. Охины усыг эрэгт гаргасан учраас
 - B. Охины дэргэд ус уудалсан учраас
 - C. Охины бээлий мод шиг унжсан учраас
 - D. Охин оймсоо өмсөхийг харсан учраас
 - E. Охин түүн рүү мишээсэн учраас
7. "Ээ бүү үзэгд гэж" гэсэн өгүүлбэрт сэтгэлийн ямар өнгө аяс илэрсэн бэ?
- A. санаахрах
 - B. гайхах
 - C. харамсах
 - D. догдлох
 - E. тохуурхах
8. "Хувингууд нь харшиж дуугарахдаа "Би усандаа явлаа шүү" гэж надад хэлдэг" гэсэн өгүүлбэрийн дүрслэх үр маягийг олоорой.
- A. адилтгал
 - B. тойруулал
 - C. ихэсгэл
 - D. хүншүүлэл
 - E. егөөдөл

9. Хүү юунаас болж зовлонд дарагдсан бэ?
- A. Норж хөлдсөн дээлийн хормой нь хөлдөөд, хоёр цагаан нэхий бээлий нь мод шиг унжсан байсан учраас
 - B. Хүйтэнд даарсандаа юу, угаас нарийхан турьгүй бие нь сөхөрчхөв үү, охин голын мөсөн дээр хөл алдан өвдөглөсөн учраас
 - C. Охиныг насан үүрд гомдоочихсон юм шиг, дахиад ер хэзээ ч усанд дагаж явахгүй болчихсон мэт бодогдсон учраас
 - D. Охин гилтгэр торгон мөсөн дээр унасан учраас
 - E. Охин гутлаа өмсөхдөө хүү рүү хараагүй учраас
10. Эхийн онцлон тодруулсан хэсгийн хэв маягийг олоорой.
- A. Хүүрнэмжийн хэв маяг
 - B. Тоочимжийн хэв маяг
 - C. Тайлбарламжийн хэв маяг
 - D. Эргэцүүлэмжийн хэв маяг
 - E. Хүүрнэмж, тайлбарламж хосолсон



ХОЁРДУГААР ХЭСЭГ - [30 ОНОО]

САНАМЖ:

1. Даалгавар тус бүрийн зааврыг анхааралтай уншиж ойлгоод гүйцэтгээрэй.
2. Даалгаврын хариуг хариултын хуудсанд тэмдэглэхгүй тул шалгалтын дэвтрийн зохих зайд бичиж тэмдэглээрэй.
3. Даалгавар бүрийн оноо харилцан адилгүй болно.

2. 1. Дараах эхийн хэсгийг уншин зөв бичих дүрмийн алдаатай 5 үг олоод, засаж бичээрэй.

Алдаатай үгийг олон зөв болгон зассан тохиолдол тус бүр 1 оноо /5 оноо/

Нарийны голын уснаа өглөөний нарны туяа нүд гялбатал тусхын үес хээрийн бэлчээрээс адуун сүргээ цуглуулчихаад, хөндий уруудуулан туусаар гурван гэрийнхээ гадуур орж ирэв. Өвгөн аав урьдын адил хазаар ногтоо тохойдоо углачихсан эхлэж адууны зүг бүртгэх мэт саравчлан харчихаад амдан очиж, хурдан хээрийг өлгөөд өгөөрэй хүү минь гэв. Баруун солгойгүй уурга сунган шидэж, зугтсан морьны толгой алддаггүй байсан гэж үе тэнгийн нөхдийнх нь шагшдагыг би өөрийн эрхгүй санадаг.

Алдаатай бичсэн үг	Засаж бичсэн үг

2.2. Дараах эхийг уншаад кирилл бичигт хөрвүүлээрэй. /5 оноо/

0-1 алдвал 5 оноо, 2-3 алдвал 4 оноо, 4-6 алдвал 3 оноо, 7-8 алдвал 2 оноо, 9-10 алдвал 1 оноо, 11-ээс дээш алдвал 0 оноотой

2.3. Зохиолч хүүхэд насандаа мэдэрсэн гэгээн хайрынхаа тухай өхөөрдөм сайхнаар дүрслэн бичжээ.
 Дээрх эхийн өнгө аяс, бичлэгийн төрлийг дуурайлган өөрт мэдрэгдсэн сайхан хайр /аав ээж, ах дүү, амраг хайр, анд нөхөд, өвөө эмээ, ах эгч.../-ын тухай гэгээн сайхнаар дурсан "Миний мэдэрсэн хайр" сэдвээр эх зохион бичнэ үү.
 Бичихдээ уншигчдад сонирхолтой, бүтэц, өнгө аяс, сэдэв, агуулгын харьцааг оновчтой гаргаж, дүр дүрслэл, баримт мэдээллийг зохистой ашиглан, хэл зүй, найруулга, зөв бичих дүрмийн алдаагүй бичээрэй. Бичгийн соёл оноонд нөлөөлнө гэдгийг анхаарна уу.
 Үгийн тоо: 200-250 /20 оноо/

Үнэлэх хүснэгт:

Даалгавар	Зөв бичих чадвар	Үндэсний бичгээр унших чадвар	Эх зохион найруулах чадвар							
			Сэдэв ба зорилго	Бүтэц	Эшлэл баримт	Бичлэгийн хэлбэр төрөл	Хэл зүйн найруулга	Үгийн тоо	Зөв бичгийн дүрэм	Бичгийн соёл
Авбал зохих оноо	5	5	5	3	2	2	3	1	3	1
Авсан оноо										



АМЖИЛТЫН БУЛАН



Юуны өмнө 2023 оны Монгол хэл бичгийн шалгалтад 800 онооны гүйцэтгэлтэйгээр шалгуулсан танд баяр хүргэе. Ийм сайхан амжилт гаргасанд аав ээж, багш нар, анд нөхөд нь их баярлаж бахархсан байх. Сэтгэгдлээ хуваалцана уу.

Баярлалаа. Огт төсөөлж байгаагүй олон хариу үйлдэл, үр нөлөө, хүмүүсийн баярласан сэтгэлийг мэдэрсэн. Монгол хэл, бичгийн шалгалт яг ЭЕШ-ын хичээлийн шалгалт биш шүү дээ. Өмнө нь авдаг их дээд сургуулийн босго шалгалт учраас 800 авна гэж огт бодож байгаагүй. Шалгалтаа хийчхээд хэд хэд шалгасан учраас хангалттай хэмжээнд хийсэн гэдэгтэй бол итгэлтэй байсан. Манай ангийн хувьд монгол хэл, бичгийн шалгалтдаа харьцангуй сайн бэлдсэн, сайн хүүхдүүд ихтэй учраас шалгалтаа өгчхөөд "Манай ангиас 800 хэд хэд гарах байх даа" гэж найзуудтайгаа ярилцаад л салж байсан юм. Орой оноогоо харчхад "Ашгүй бүтэн оноо авчхаж" гэж баярлаад найзууддаа хэлж байсан. Манай найзууд ч өндөр оноотой байсан болохоор бие биедээ баяр хүргээд, баярлаад л өнгөрсөн. Харин маргааш нь сургуулиас ганцаараа 800 оноо авсан гэдгээ сонсоод их гайхсан даа. Багш нар маань ч их баярласан. Аав маань хамгийн ихээр бахархаж, баярласан. Хүүхэд шиг л хөөрсөн дөө.

Мөн шалгалтын онооныхоо ачаар цагийн багшаар их эрэлттэй ажиллаж байгаа шүү. (инээв)

Аль сургуулийг төгссөн, одоо аль сургуульд ямар мэргэжлээр сурч байна вэ? Өөрийнхөө тухай товч танилцуулна уу?

Намайг Бадмаанямбуугийн Хатанзаяа гэдэг. Нийслэлийн ЧД-ийн лаборатори 23 дугаар сургуулийн Орос хэлний ангийг төгссөн. Одоо Монгол улсын их сургуульд "Улс төр судлал"-ын чиглэлээр суралцаж байна.

Шалгалтдаа яаж бэлдсэн, хэр удаан хугацаанд бэлдсэн талаараа ярина уу?

Хичээлийн сүүлийн улирал эхлээд багш нар маань биднийг шалгалтад бэлдэж эхэлсэн. Сургуулийн давтлагын үеэр болон шалгалт болохоос өмнө багш нарынхаа бидэнд хэлж, зөвлөсөн зүйлс, өөрийн олж харсан зүйлс дээр анализ хийн тус шалгалтыг хийх өөрийн арга барилыг тодорхойлж, нэгтгэх байдлаар бэлдсэн.

Шалгалтад бэлдсэн багш нарынхаа талаар ярина уу? Ямар зөвлөгөө өгч байсан бэ?

Монгол хэл бичгийн шалгалтын хувьд манай анги удирдсан багш Ш.Уранчимэг болон монгол хэл, уран зохиолын Б.Батчимэг багш нар маань анхаарч бэлдүүлсэн. Түүний үр дүнд манайх ангиараа шалгалтаа амжилттай давсан. Анги удирдсан багш маань Орос хэлний багш хэдий ч хичээл тарсны дараа биднийг тогтмол суулгаж бэлдүүлдэг байсан. Тэгэхдээ үндэсний бичигтэй сайн хүүхдүүддээ сул байгаа 1-2 хүүхдийг даалгаж өгөн нэгнийгээ үндэсний бичгээр уншуулж, баг болон бэлддэг байсан. Түүний үр дүнд хүүхдүүд маш хурдан сайжирцгаасан. Б.Батчимэг багш маань шалгалтын хэсэг бүрийг нарийн тайлбарлан монгол хэл, бичгийн шалгалтын суурь ойлголтыг маш сайн өгсөн. Аливаа зүйлийн үндэс хамгийн чухал байдаг шүү дээ. Дараагаар нь тус шалгалттай холбоотой дасгал даалгавар хийлгүүлж, сайн бичигдсэн эсээ уншиж өгч, өмнө нь өөрөө засалт дээр ажиллах үедээ ямар эсээ илүүтэй сэтгэлд нь хүрч байсан тухай ярьж өгдөг байлаа. Мөн олон төрлийн сэдвээр эсээ бичүүлж, сайн бичсэн хүүхдүүдийнхийг дамжуулан уншуулдаг байсан юм. Тэрний үр дүнд шалгалтын эсээг бичихэд сэдэв нь өөр байсан ч өмнө нь бичиж байсан юм шиг л танил санагдаж, асуудалгүй бичсэн. Хүүхдүүд зөв бичгийн дүрэм дээр тийм ч их алдаад байдаггүй ч дүрмээрээ цээжлээгүй, нүдэнд дассанаараа цээжилчихсэн байдаг шүү дээ. Би ч тэгдэг байсан юм. Гэхдээ бичихдээ эргэлздэг хэд хэдэн төрлийн үгнүүд байдаг байсан. Түүнийгээ сургуулийн давтлагын үеэр дүрмээр нь толгойн дотроо хийж авсан нь их хэрэг болсон.

Шалгалтын хугацаа хэр хангалттай байсан бэ?

Монгол хэл, бичгийн шалгалтыг 100 минутад хийж гүйцэтгэдэг. Миний хувьд шалгалтын хугацаа дуусахаас 30 минутын өмнө дуусгаад, үлдсэн хугацаандаа шалгалтын материалаа эхнээс нь хэд хэд шалгаж амжсан. Шалгалтын хугацаа хангалттай байсан.

Шалгалтад амжилт үзүүлэхэд хамгийн гол юу нөлөөлсөн гэж бодож байна вэ?

Сэтгэл санаа маань тогтвортой, тайван байсан нь их нөлөөлсөн байх гэж боддог. Хүн ямар нэгэн зүйлд хэт их анхаарал хандуулаад, огт алдаа гаргахгүй гэж бодохоороо л алддаг юм шиг санагдсан. Би Монгол хэл, бичгийн шалгалтад огт 800 оноо авна гэж бодож байгаагүй. Хийчхээд л гараад ирнэ дээ л гэж боддог байсан юм. Харин хамгийн их алдахыг хүсээгүй хичээл дээрээ санасандаа хүргэж чадаагүй. Тиймээс шалгалтаа өгөхдөө олон зүйл бодож толгойгоо дүүргэлгүйгээр өнгөрсөн хугацаанд хийж бэлдсэн зүйлээ л хийгээд гараад ирэхэд болно.

Үүнээс гадна мэдээж Б.Батчимэг багшийн маань олон сэдвээр эсээ бичүүлж, бэлдүүлсэн нь шалгалтаа түүртэхгүй хийхэд их нөлөөлсөн.

Шалгалтын үед гол анхаарах зүйл юу байсан бэ?

Өмнө нь дурдсанчлан сэтгэл санаагаа тайван байлгах хамгийн чухал байсан. Гэхдээ шалгалтын өмнөх бэлтгэлээ хангалттай хийгээд, өөрийгөө бэлдчихсэн байсан учраас шалгалтын үеэр анхаарах, сандрах зүйл тийм ч их гараагүй. Шалгалтын үеэр гарч болох эрсдэлээ тооцоолоод бүх бэлтгэлээ хангаад орох хэрэгтэй. "Харандаа хугарвал эсвэл цаанаас өгөгдсөн харандаа тод гарахгүй байвал надад илүү харандаа хэрэгтэй. Үзэг тасалдвал надад илүү үзэг хэрэгтэй. Шалгалтын үеэр нойр хүрч магадгүй учраас би нойроо авсан байх хэрэгтэй" г.м. Шалгалтын үеэр сайн төвлөрч өгөхгүй бол 3 удаа гүнзгий амьсгаа аваад дахиад эхлээрэй гэж зөвлөмөөр байна. Мөн шалгалтын үеэр тодорхой хэмжээнд ангид чимээ гардаг. Ханиад хүрсэн хүүхэд байвал ханиалгах, нусаа татах, гэдэс нь дуугарах, цонхоор чимээ гарах, сандарсан үедээ хүүхэд нэг давтамжтай чимээ гаргах ч тохиолдол бий. Тиймээс шалгалтад бэлдэж байх хугацаандаа огт чимээгүй, нам гүм газар байхаасаа илүү тодорхой чимээнд хичээлээ хийж сурах хэрэгтэй. Тэгвэл шалгалтын үеэр ямар ч чимээ гарсан анхаарал чинь сарнихгүй. Дүгнээд хэлбэл шалгалтаас өмнө өөрөөсөө ямагт "Хэрвээ?" гэж асуух хэрэгтэй. Харин

шалгалтын үеэр “Яах вэ? Яана аа?” гэсэн бодлоо авч хаяад бэлтгэгдэж, хуяглагдсан дайчин шиг тайван байгаарай.

Шалгалтын даалгавар, хариултын хуудас зэрэг материалтай ажиллахад хэр тохиромжтой байсан бэ? Ямар нэгэн хүндрэл бэрхшээл гарсан уу?

Сургуулиас жишиг шалгалт хэд хэдэн удаа авч байсан болохоор шалгалтын материалын ерөнхий бүтцийг мэддэг болчихсон, гарт орчихсон байсан. Тиймээс шалгалтын материалтай ажиллахад бэрхшээлтэй зүйл гараагүй ээ. Өөрийн өгөх шалгалтын жишиг материалыг яг шалгалт өгч байгаа мэт тогтмол өгч өөрийгөө дасгах нь шалгалтын үеэр тайван байх, цагаа зөв хуваарилах зэрэгт маш чухал нөлөө үзүүлдэг санагддаг.

Өмнө нь Монгол хэлний хичээлээр олимпиад, уралдаанд орж байсан уу? Ямар амжилтууд гаргаж байсан талаараа ярина уу?

Яг энэ хичээлтэй холбоотой том тэмцээн, уралдаанд орж байгаагүй учраас сайн санадаггүй ээ. Ямартай ч эсээ бичлэг, илтгэл, мэтгэлцээний тэмцээнд л их оролцдог байсан.

Мэргэжлээ сонгохдоо өөрийн сонирхлоороо сонгосон уу? Аав ээж, найз нөхөд нь нөлөөлсөн үү? Босго оноо нөлөөлсөн үү?

Ямар нэгэн нөлөөлөлгүйгээр мэргэжлээ өөрийн шийдвэрээр сонгосон.

Энэ жил анх удаа Элсэлтийн шалгалт өгөх дүү нартаа сургамж болгон шалгалтад орохынхоо өмнө юуг анхаарвал зохих талаар зөвлөгөө өгнө үү?

Ямар ч зүйл дээр өөрийн арга барилыг олох хамгийн чухал. Чи өөрийн арга барилыг олохын тулд шалгалтаасаа долоо хоногийн өмнө биш, өмнөх өдөр нь биш дор хаяж 1-3 сарын хугацаанд тогтмол бага багаар олон хэлбэрээр бэлдсэн байх хэрэгтэй. Хүн хүний сурах, тогтоох арга барил өөр учраас шууд ингэ, тэг гэвэл алдаа болох байх. Миний хувьд шалгалт өгөх өдрийнхөө өглөө бүх бэлдсэн зүйлээ эхнээс нь гүйлгэж харж уншчихаад ордог байсан. Харин зарим хүүхдүүд шалгалт өгөх өдрөө огт хардаггүй. Тиймээс яг аль нь надад илүү дээр вэ? Гэдгээ л олж мэдэх нь чухал.

Нийгмийн ухааны Г.Бат-Учрал багш маань ЭЕШ-д их олон талаас бэлдүүлдэг байсан. Түүнээс олон хичээлийн шалгалт нэг өдөр өгөхөөр бол өмнөх хичээлийн дүнгээ шалгалт өгөхийнхөө өмнө битгий хараарай гэдэг байсан. Хүн сэтгэлийн амьтан болохоор өмнөх шалгалтын дүн нь санасанд нь хүрэхгүй бол сэтгэлээр унаад, тогтворгүй болчихдог. Харин боломжийн байвал хэт хөөрчихдөг тал бий. Багшийнхаа зөвлөснөөр сүүлийн хичээлийнхээ оноог л танхимд байхдаа харсан даа. Бусдаар нүдээ тас аниад л гарч

ирдэг байсан (инээв). Мөн хэрэг болох бяцхан зөвлөмжүүдийг өгвөл:

Шалгалт өгөх өдрийнхөө өглөө хөнгөхөн хооллоод жижигхэн хар шоколад идээд орох. Өлсөж болохгүй. Цадаж болохгүй.

Шалгалт өгөх өдрөө юм уу, шалгалтын өмнөх өдрийнхөө орой өөрийн мэдэрч байгаа мэдрэмжүүдээ цаасан дээр бичих.

Бүтэн нойр авах. Бага унтаж болохгүй. Их унтаж болохгүй.

Шалгалтын өмнөх өдрөө унтахынхаа өмнө нүдээ аниад яг шалгалт өгч байгаа мэт төсөөлөх. Өглөө сэрээд шалгалт өгөх сургууль руугаа явж байгаагаас эхлээд шалгалтаа хийж дуусах хүртэлх бүх үйл явцаа төсөөлөөд унтах.

Бичиг баримт, илүү харандаа баллуур г.м зүйлсээ нэг хавтсанд хийж бэлдэх.

Төгсөх жил, шалгалтад бэлдэж байх үе хамгийн дурсамжтай, сургамжтай, нандигнаж хайрламаар үе учраас үлдсэн хугацаагаа битгий аргацааж өнгөрүүлээрэй. Хуягаа бүрэн тоноглоод тулалдах өдрөө хийх зүйлээ хийчхээд л гараад ирээрэй. Чиний алганд бүх зүйл байгаа.

Эх орныхоо хөгжилд ямар хувь нэмэр оруулъя гэж бодож байна вэ?

Эх орныхоо үнэ цэнийг мэддэг, олон талын талыг мэдлэг чадвартай боловсон хүчин болж л хувь нэмрээ оруулъя гэж бодож байна даа.

Сүүлийн асуултыг танд үлдээе.

Олон өдрийн нарны заримыг аргадаж, заримтай нь тэмцэж, хаа нэг нүдээ аниад бүх л өдөржин хэвтэж, хүчтэй заримдаа сул дорой хамгийн гол нь ДҮҮРЭН амьдардаг юм шүү. Амьдралынхаа хамгийн хөөрхөн өдрүүдийг мэдэрч чадах мэдрэмж бүрээ дүүрэн мэдэрч өнгөрүүлээрэй.

(Монгол хэл, бичгээ битгий умартаж хаяарай. Амьдрал дээр ч, их сургуульд ороод ч бүхий л хичээл дээр бичих, ярих шаардлага гардаг. Судалгааны тайлан, номын шүүмж, эсээ, бие даалт гээд бүхий л зүйлд чамаас зөв сайхан бичих, ярих чадварыг шаардана. Тиймээс дан ганц шалгалтын төлөө биш өөрийнхөө төлөө үүргээ ухамсарлаад эх хэлээ хайрлаж сураасай.)

За баярлалаа. Цаашдын сурлагад тань илүү их амжилт хүсье.


Баярлалаа.

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТЫН ОНЛАЙН БҮРТГЭЛИЙН АЛХАМ



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ШАЛГУУЛАГЧИЙН БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

- Өргөдөл
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Бүртгэлийн хуудас
- Эмчийн магадлагаа, тодорхойлолт
- Сургуулийн тодорхойлолт, албан бичиг



Ямар төрлийн хөгжлийн бэрхшээлтэй болон ямар хичээлээр шалгалт өгөх тухай өргөдөлд дурдах бөгөөд үүнээс шалтгаалан шалгалтын анги танхимыг бэлтгэнэ.



Юуны өмнө 2023 оны Математикийн хичээлд 800 онооны гүйцэтгэлтэйгээр шалгуулсан танд баяр хүргэе.

Ийм сайхан амжилт гаргасанд аав ээж, багш нар, анд нөхөд нь их баярлаж бахарсан байх. Сэтгэгдлээ хуваалцана уу.

-Баярлалаа. Хүлээлгийн танхимаас анхны оноогоо харчхаад гарсны дараа математикийн багш /ангийн багш/ маань дуудахад гүйж очоод багшдаа оноогоо хэлээд хамтдаа баярлах тэрхүү агшин одоо ч тодхон санагдаж байна. Гэртээ амьсгаа даран хүлээж буй аав ээждээ очиж хэлээд л бөөн баяр болсон доо. Магадгүй аав ээж, гэр бүлээ мөн найз нөхдөө хамгийн ихээр баярлуулсан мөчүүдийн нэг байх.

Аль сургуулийг төгссөн, одоо аль сургуульд ямар мэргэжлээр сурч байна вэ? Өөрийнхөө тухай товч танилцуулна уу?

-Намайг Очирхүүгийн Бумбаяр гэдэг. Би Завхан аймгийн Улиастай сумын Ерөнхий боловсролын Чандмань-Эрдэнэ сургуулийг Б.Нямдаваа багштай 12а ангид суралцан 2023 онд төгссөн. МУИС-д Нано шинжлэх ухаан, технологи мэргэжлийг сонгон суралцаж байгаа.

Шалгалтдаа яаж бэлдсэн, хэр удаан хугацаанд бэлдсэн талаараа ярина уу?

-Бэлтгэлийн хувьд бол 10-р ангиасаа эхлэн онолын ойлголтууд тэдгээрийн мөн чанарыг нь ойлгохыг хичээж, 12-р ангиас шалгалт өгөх буюу мэдсэн сурсан зүйлээ ашиглахдаа илүү их шамдаж бэлдсэн. Бэлтгэлийг үр дүнтэй байлгахын тулд удаан цагаар сууж ачаалал даах чадвараа нэмэгдүүлсэн нь үр дүнгээ өгсөн гэж бодож байна.

Шалгалтад бэлдсэн багш нарынхаа талаар ярина уу? Ямар зөвлөгөө өгч байсан бэ?

-Багш маань бидний өмнөх үеийн шавь нарынхаа амжилтын түүх, тэд бэлтгэлээ хэрхэн хийсэн талаарх аргуудаас хуваалцан, ямар ч хүн үргэлж суралцах ёстойг сануулдаг. Хэдий багш маань шалгалтын өмнөх бэлтгэлийн хугацаанд бидэнтэй байж чадаагүй ч гэсэн, 800 оноо авч багшийнхаа итгэлийг дааж чадсандаа баярлаж мөн багшаараа бахархаж явдаг.

Шалгалтын хугацаа хэр хангалттай байсан бэ? Даалгавраа хэр хугацаанд гүйцэтгэж амжсан талаар

-Жил бүрийн шалгалтын материалыг хугацаатай ажиллаж үзэхэд 2023 оны шалгалтын бодлогууд урьд онуудынхаас илүү анхаарал болгоомж, гүн гүнзгий төвлөрөл шаардсан нь анзаарагдсан. Хугацаандаа багтаж гүйцэтгээд эргээд хоёр удаа бүтэн хянаж амжсан.

Шалгалтад амжилт үзүүлэхэд хамгийн гол юу нөлөөлсөн гэж бодож байна вэ?

-Хамгийн чухал зүйл бол бэлтгэл. Сэтгэл зүйн болон бие физиологийн хувьд. Бэлтгэл хийх явцдаа жишиг шалгалтуудыг олон удаа гүйцэтгэж сандралаа дарж чадсан мөн бодлого бодох хурдаа нэмэгдүүлж чадсан нь амжилт гаргах үндэс байсан болов уу гэж бодож байна. Мөн багшийн өгч буй цэгцтэй онолын ойлголтууд ба хэлж байсан санамжууд их хэрэг болсон.

Шалгалтын үед гол анхаарах зүйл юу байсан бэ?

-Цагаа хянаж, бодлого тус бүр дээр цагаа зөв хуваарилснаар сэтгэл зүйн давуу тал болдог. Мөн сандралгүйгээр шалгагчийн санаа буюу бодлогын учрыг аль болох богино хугацаанд сайтар ойлгохыг хичээх хэрэгтэй. Яаран сандран бодвол буруу хариулт тестэн дунд байдаг учраас хариултаа будахаас өмнө ахин нэг удаа бодлогоо уншиж, шалгах хэрэгтэй гэж боддог.

Шалгалтын даалгавар, хариултын хуудас зэрэг материалтай ажиллахад хэр тохиромжтой байсан бэ? Ямар нэгэн хүндрэл бэрхшээл гарсан уу?

-Миний хувьд бодсон бодлогынхоо хариуг шууд хариултын хуудсан дээрээ будах нь илүү хэрэгтэй гэж боддог. Учир нь дараа дараагийн бодлогууд дээр гацаж магадгүй, тиймээс найдвартай бодсон бодлогуудаа будах нь цаг дуусах үед яарч сандрахгүй байхад тус болдог. Материалын хувьд бодолтоо бичих чөлөөт хэсэг их байдаг тул бодолт хийхэд асуудал байгаагүй.

Өмнө нь Математикийн хичээлээр олимпиад, уралдаанд орж байсан уу? Ямар амжилтууд гаргаж байсан талаар

-Аймгийн чанартай хэд хэдэн олимпиадад оролцож шагналт байруудыг эзэлж байсан.

Мэргэжлээ сонгохдоо өөрийн сонирхлоороо сонгосон уу? Аав ээж, найз нөхөд нь нөлөөлсөн үү? Босго оноо нөлөөлсөн үү?

-Шинжлэх ухааныг сонирхож, тэдгээрийн зүй тогтлыг илүү нарийн судлах хүсэлтэй байсан учраас Нано технологи мэргэжлийг сонгосон. Тогтоосон босго онооноос илүү шалгалт өгч буй бусад сурагчидтай өрсөлддөг учир босго оноогоор өөрийгөө хязгаарлаж болохгүй.

Энэ жил анх удаа Элсэлтийн шалгалт өгөх дүү нартаа сургамж болгон шалгалтад орохынхоо өмнө юуг анхаарвал зохих талаар зөвлөгөө өгнө үү?

-Өөрийнхөө гаргасан хичээл зүтгэлдээ итгэлтэй байгаа бол сандрах хэрэггүй гэж хэлмээр байна. Ямар нэгэн анхаарал сарниулах зүйл бодолгүйгээр шалгалт эхлэхийн өмнөх хугацаанд төвлөрөх хэрэгтэй байдаг. ЭЕШ чиний амьдралыг бүтнээр нь шийддэггүй ч тодорхой хэмжээгээр нөлөөлдөг учраас хожим харамсахгүйн тулд нойргүй шөнө, шантармаар үеүдээ даван туулаарай гэж хэлье.

Эх орныхоо хөгжилд ямар хувь нэмэр оруулья гэж бодож байна вэ?


-Шинжлэх ухаан болон технологийн хувьд мөн боловсролын салбарт манай улс дутмаг талтай санагддаг. Тиймээс эдгээр салбаруудад ажиллахыг хүсдэг.

Элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт гаргахад нөлөөлсөн өөрийн гэсэн зарчим, үлгэр жишээ авдаг хүн байгаа юу?

-Хөдөлмөр эзнээсээ урвадаггүй гэдэг үг миний зарчим болдог. Үлгэр жишээ авдаг маш олон хүн байгаа ч хамгийн дотнын хүн болох ээжээсээ үргэлж суралцдаг. Миний гаргасан амжилт бүхний цаана гэр бүл, багш нар, найз нөхөд минь байдаг учраас тэднээрээ маш их бахархдаг.

За баярлалаа. Цаашдын сурлагад тань илүү их амжилт хүсье.

-Баярлалаа.





Юуны өмнө 2023 оны Англи хэлний хичээлд 800 онооны гүйцэтгэлтэйгээр шалгуулсан явдалд баяр хүргэе.

Ийм сайхан амжилт гаргасанд аав ээж, багш нар, анд нөхөд нь их баярлаж бахарсан байх. Сэтгэгдлээ хуваалцна уу.

Баярлалаа. Миний хувьд анхны оноогоо хараад аймгаасаа нэгээр гарсандаа маш их баярласан хэдий ч надаас илүү баярлаж байсан хүмүүс бол миний хамгийн сайн найзууд маань байсан. Маргааш нь 800 оноо авсанаа мэдээд ээждээ хамгийн түрүүнд хэлэхэд хамгийн гоё мэдрэмжийг авсан, цаанаасаа уйлах гээд хэхэ.

Аль сургуулийг төгссөн, одоо аль сургуульд ямар мэргэжлээр сурч байна вэ? Өөрийнхөө тухай товч танилцуулна уу?

Би Ховд аймгийн Жаргалант сумын улсын тэргүүний Цаст-Алтай сургуулийг 2023 онд төгссөн. Өнгөрсөн намар "Илгээлт-2100" тэтгэлэгт тэнцэн одоо түүнийхээ бэлтгэл хөтөлбөрт сурч байгаа.

Шалгалтдаа яаж бэлдсэн, хэр удаан хугацаанд бэлдсэн талаараа ярина уу?

Би багын л Англи хэлний суурь сайтай байсан ч өмнө нь тийм ч их хийдэггүй байсан. Харин яг ЭЕШ -ын түвшинд бэлдэж эхэлсэн гэвэл 11-р ангийн хавар байсан байх аа. Гэхдээ 800 оноо авъя гэж бодож байвал маш олон нэмэлт зүйлс хийх шаардлагатай санагддаг. Миний хувьд IELTS, SAT-ын шалгалтад хувиараа бэлдэж өгснөөрөө англи хэлнийхээ ерөнхий мэдлэгээ зузаатгасан.

Шалгалтад бэлдсэн багш нарынхаа талаар ярина уу? Ямар зөвлөгөө өгч байсан талаар

Надад зааж сургасан багш гэвэл сонгоны багш Отгонбаяр, ACCESS хөтөлбөрийн маань багш Шүрэнцэцэг, Лхамзаяа, Буянхишиг нар мөн ээж маань байсан.

Багш нар маань бүгд надад итгэж байсан болохоор яг үнэндээ шалгалтын өмнө нээх олон зөвлөгөө аваагүй ээ, хариултын хуудсаал гоё будаарай гэж зөвлөсөндөө.

Шалгалтын хугацаа хэр хангалттай байсан бэ? Даалгавраа хэр хугацаанд гүйцэтгэж амжсан талаар

Англи хэлний хичээлийн хувьд тийм ч их цаг шаарддаг хичээл биш. ЭЕШ-ийн материалыг шалгуулагч аваад ядаж 30 минутанд хийдэг болох хэрэгтэй. Миний хувьд сэдвээ эхний байдлаар 16 минутанд хийсэн. Дараагийн 20 минутыг эргэн харж алдаа гаргасан эсэхээ олоход зарцуулан үлдсэн хугацаанд хариултын хуудсаа бөгөлсөн.

Шалгалтад амжилт үзүүлэхэд хамгийн гол юу нөлөөлсөн гэж бодож байна вэ?

Сэтгэл зүй л хамгийн чухал нь байдаг юм билээ. Өмнө нь сорилуудаа сайн хийдэг байсан болоод ч тэр үү шалгалтад ямар ч сандралгүй орсон (Харин ч бүр шалгалтын явцад инээд хүрээд байсан хха). Гэтэл бусад хүүхдүүдийг харахад сандрал нь арилаагүй гарж ирж байсан.

Шалгалтын үед гол анхаарах зүйл юу байсан бэ?

Түвшнээс үл хамааран бүх өгөхөөр төлөвлөж байгаа дүү нартаа хэлэхэд хурд,нямбай байдал, будалт, сэтгэл зүй дээрээ анхаарч чадвал дажгүй оноо авах боломжтой байдаг. Тийм ч учраас эдгээр зүйл дээр анхаараасай гэж хүсэж байна.

Шалгалтын даалгавар, хариултын хуудас зэрэг материалтай ажиллахад хэр тохиромжтой байсан бэ? Ямар нэгэн хүндрэл бэрхшээл гарсан уу?

Харандаа, баллуур, шалгалтын материал зэрэг зүйлс нь стандартын дагуу, маш гоё байсан. Харин хариултын хуудасны тухайд асуудал гарсан. Өмнө нь зөндөө хариултын хуудас будаж байсан ч бодсоноос нүднийх нь хэмжээ маш жижиг ирсэн тул гадуур нь будахгүй байх гэж их хичээж илүү цаг үлдээх хэрэг гарсан.

Өмнө нь Англи хэлний хичээлээр олимпиад, уралдаанд орж байсан уу? Ямар амжилтууд гаргаж байсан талаар

Би ахлах ангидаа Олон улс, улс, аймгийн хэмжээнд олон олон олимпиадуудад оролцож байсан. Нийт англи хэлээр аймгийн 3 алт, 1 мөнгө, 2 хүрэл медал мөн улсын мэргэжлийн хичээлийн олимпиадын 2-р шатны 2-р байртай. Түүнчлэн Нippo олон улсын олипиадны 2-р шатанд 2 удаа тэнцэж байсан амжилтууд гаргаж байсан.

Мэргэжлээ сонгохдоо өөрийн сонирхлоороо сонгосон уу? Аав ээж, найз нөхөд нь нөлөөлсөн үү? Босго оноо нөлөөлсөн үү?

Хэдий миний хувьд сонирхолтой гэж үзсэн өөр салбар байсан ч Монголд ирээдүйгүй

тул зорилгоо өөрчилхөөр болсон. Харин одоо би Computer Science - аар сурахаар төлөвлөж байгаа. Энэ шийдвэрийг аав ээжтэйгээ зөвлөлдөн гаргасан бөгөөд өмнө нь сонирхож байсан салбар руу маань хүртэл хөрвөх боломжтой тул маш их таалагдаж байгаа.

Энэ жил анх удаа Элсэлтийн шалгалт өгөх дүү нартаа сургамж болгон шалгалтад орохынхоо өмнө юуг анхаарвал зохих талаар зөвлөгөө өгнө үү?

Их сургуульд явснаасаа хойшоо миний анзаарсан зүйл бол оюутнууд ер нь ямар ч шалгалтад хийснийхээ хэрээр л дүн авдаг юм билээ.Сайн бодвол ЭЕШ ч гэсэн ялгаагүй. Үүнийг мэдэхгүй хүүхдүүдэд амьдралынх нь анхны жинхэнэ шалгуур болж ирдэг тул ЭЕШ-дээ муу өгөх тохиолдол гардаг. Тийм ч учраас миний зүгээс хэлэх зүйл бол их сургуульд бэлэн бай, оюутан шиг сэтгэ, бэлтгэлээ тултал нь хий (гэхдээ гол нь өөрт тохирсон арга барилаа эрт ол).

Эх орныхоо хөгжилд ямар хувь нэмэр оруулья гэж бодож байна вэ?

Би "Илгээлт-2100" тэтгэлэгт тэнцсэнээрээ гадаадын топ 100-д багтах их дээд сургуульд үнэгүй сурах боломжтой болсон. Тийм ч учраас энэхүү боломжоо ашиглан дэлхийд үнэлэгдэх өндөр боловсрол түүнчлэн тухайн улсынхаа соёлыг судалж ирээд Монголдоо тэр тусмаа аймагтаа ажиллаж амьдрах зорилготой байгаа. Бусад залуусыг ч бас тэгээсэй гэж уриалмаар байна аа.

Сүүлийн асуултыг танд үлдээе.

Хамгийн сүүлд хэлэхэд ЭЕШ-д зөв бэлдсэнээрээ та өөрөөрөө бахархах, түүнчлэн ойр дотныхон чинь таниар бахархах амжилтыг гаргаж чадна. Тиимээс өөрийн гэсэн арга барилаа эртнээс олж, аливаа хичээлийг дурлаж хийдэг байгаасай гэж хүсэж байна.

За баярлалаа. Цаашдын сурлагад тань илүү их амжилт хүсье.

Намайг урин оролцуулсан БҮТ-дээ маш их баярлалаа. Энэ нийтлэлийг уншсан бүх ЭЕШ өгөх дүү нартаа амжилт хүсье ээ. Зөв бэлдвэл 800 авах амархан.





Юуны өмнө 2023 оны Нийгэм судлалын хичээлд 800 онооны гүйцэтгэлтэйгээр шалгуулсан явдалд баяр хүргэе. Ийм сайхан амжилт гаргасанд аав ээж, багш нар, анд нөхөд нь их баярлаж бахархсан байх. Сэтгэгдлээ хуваалцна уу?

-Тэгэлгүй яахав. Гэр бүл найз нөхөд багш нар гээд бүгд их найдаж байсан болохоор 800 оноо авахад бүгд их баярлаж бахархсан. Багш маань харах болгондоо инээгээд, аав ээжийн найзууд, хамаатан садангууд маань бүгд баяр хүргэж байсан болохоор их баяртай байсан.

Аль сургуулийг төгссөн, одоо аль сургуульд ямар мэргэжлээр сурч байна вэ? Өөрийнхөө тухай товч танилцуулна уу?

Намайг Энхтайваны Оюунбилэг гэдэг. 18 настай. Би Баянхонгор аймгийн Соого Сейкео ахлах сургуулийг 2023 онд төгссөн. Одоо МУИС-ийн Сэтгэл судлалын тэнхимийн 1 дүгээр түвшний оюутан.

Шалгалтдаа яаж бэлдсэн, хэр удаан хугацаанд бэлдсэн талаараа ярина уу?

Шалгалтдаа 12 дугаар ангидаа ороод л бэлдэж эхэлсэн. Хийж байгаа зүйлээ үр дүнтэй байлгая гэвэл шаргуу хичээл зүтгэл хэрэгтэй гэж би боддог. Тийм ч учраас 9 сараас эхлээд л тасралтгүй бэлдэж эхэлсэн. Хүний тархи өглөө хамгийн идэвхитэй ажилладаг учраас өглөө эрт босож хичээлдээ явахасаа өмнө номоо уншиж цээжилж байгаад хичээлдээ явдаг байсан. Тэгээд цээжилсэн зүйлээ өдөр нь багшдаа шалгуулаад тест ажиллах, өөрөө тест зохиох аргаар бэлддэг байсан.

Шалгалтад бэлдсэн багш нарынхаа талаар ярина уу? Ямар зөвлөгөө өгч байсан талаар

Намайг Д.Одсайхан, Д.Бадамгарав багш нар маань бэлдсэн. Мөн ангийн багш Ж.Нацагбадам, сургуулийн захирал Д.Цэдэнсодном гээд сургуулийн маань бүх багш нар маань биднийг дэмжиж

зарим ажлуудыг ч зохион байгуулж байсан. 2022 оны 10 сарын сүүлчээр бид нар Улаанбаатар хотод очиж өөрсдийн орохыг хүсэж байгаа сургуулиудтайгаа танилцах аялал хийсэн. Бас хаврын уртад ядарч дархлаа унадаг болохоор бүгдэд нь дусал хүртэл хийлгүүлсэн. Багш нар маань биднийг үнэхээр чин сэтгэлээрээ дэмжиж тусалж байсан болохоор 800 оноо авахад илүү хялбар байсан.

Шалгалтын хугацаа хэр хангалттай байсан бэ? Даалгавраа хэр хугацаанд гүйцэтгэж амжсан талаар

Шалгалтад орохдоо миний хамгийн их анхаарсан зүйл маань цагтай ажиллах, хариултын хуудсаа зөв будах байсан. Би бүх зүйлээ мэдэж байгаа ч цагтаа амжиж хариултын хуудсаа будахгүй бол ямар ч хэрэггүй шүү дээ. Тиймээс цагтаа амжихгүй бол яанаа, хариултын хуудсаа буруу будчихвал яанаа гэсэн айдас их байсан ч яг хариултын хуудсаа будаж дуусах үед цаг дуусаж таарсан учраас цаг хангалттай байсан гэж бодож байна.

Шалгалтад амжилт үзүүлэхэд хамгийн гол юу нөлөөлсөн гэж бодож байна вэ?

Маш олон зүйл нөлөөлсөн. Тэр дундаас хамгийн их нөлөөлсөн зүйл нь надад итгэж найдаж байгаа гэр бүл найз нөхөд багш нарынхаа итгэлийг алдахгүй юм шүү гэсэн бодол байсан. Тиймээс тэд нарынхаа итгэлийг алдахгүйн тулд өөрийгөө маш их дайчилж хичээсэн.

Шалгалтын үед гол анхаарах зүйл юу байсан бэ?

Шалгалтын үед гол анхаарах зүйл бол сандралгүй өөртөө итгэлтэй байх. Яагаад гэвэл сандарсан үед цээжилсэн зүйлээ мартаж, хариултын хуудсаа буруу будах, хариултаа зөрүүлэх эсвэл өөртөө итгэлгүй байдлаас болж энэ хариулт нь буруу байвал яанаа гээд бодох магадлалтай. Тиймээс сандарч тэвдэхгүй байхыг хичээх хэрэгтэй.

Шалгалтын даалгавар, хариултын хуудас зэрэг материалтай ажиллахад хэр тохиромжтой байсан бэ? Ямар нэгэн хүндрэл бэрхшээл гарсан уу?

Хариултын хуудсан дээрээ эртнээс ажиллаж байвал илүү хялбар байна байх. Миний хувьд ямар нэгэн бэрхшээл байгаагүй ч хувийн зохион байгуулалттай байж шалгалтын материал, хариултын хуудас, хариултыг хуудсан дээр наадаг баганан код гээд бүгдийг нь ямар нэгэн алдаатай байна уу гэдгийг нь сайн шалгаад үзэхэд гэмгүй.

Өмнө нь энэ хичээлээр олимпиад, уралдаанд орж байсан уу? Ямар амжилтууд гаргаж байсан талаар

Өмнө нийгмийн хичээлээр төрөлжсөн олимпиадын 2 дугаар шатанд орсон ч анзааргаагүй байдлаасаа болоод 5 дугаар байранд орж байсан.

Мэргэжлээ сонгохдоо өөрийн сонирхлоороо сонгосон уу? Аав ээж, найз нөхөд нь нөлөөлсөн үү? Босго оноо нөлөөлсөн үү?

Мэргэжлээ өөрийн бодлоор сонгосон. МУИС-ийн сэтгэл судлалын ангийн хуваарь их цөөхөн ирдэг болохоор орж чадах болов уу? гэсэн бодол байсан. 800 оноо авч чадсанаар хүссэн ангидаа төвөггүй орж чадсан.

Энэ жил анх удаа Элсэлтийн шалгалт өгөх дүү нартаа сургамж болгон шалгалтад орохынхоо өмнө юуг анхаарвал зохих талаар зөвлөгөө өгнө үү?

Юуны өмнө сэтгэл зүйн байдал их чухал. Тийм учраас шалгалт өгөхийнхөө өмнө янз бүрийн лам бөө дээр очихгүй байхыг зөвлөө. Бас шалгалтад орохынхоо өглөө хөнгөхөн юм идээд дуртай дуугаа сонсоод дуртай амттанаа идсэн ч болно харин битгий хэтрүүлээрэй. Хамгийн гол зүйл нь бүх юм өөрөөс чинь шалтгаална гэдгийг санаад өөртөө итгэлтэй, хамгийн сайнаараа хичээх нь их чухал шүү.

Эх орныхоо хөгжилд ямар хувь нэмэр оруулья гэж бодож байна вэ?

Яг одоогоор манай улсад Сэтгэл судлалын шинжлэх ухаан эрчимтэй хөгжиж байгаа шүү дээ. Тийм ч учраас цаашдаа ихийг сурч мэдээд өөрийн бүхий л хүч чадлаа сэтгэл судлалын шинжлэх ухаанд зориулна гэж боддог.

Сүүлийн асуултыг танд үлдээе.

Юуны өмнө мэргэжил сонголт их чухал. Сэтгэл хөдлөлөөрөө шийдэж огт болохгүй. Гэр бүлтэйгээ ярилцаж байгаад өөрийнхөө сонирхдог дуртай зүйлээ сонгоорой. Мөн хичээл хичээл гээд эрүүл мэндээ хаяж огт болохгүй. Түргэн хоол бага идэж эрүүл хүнс хэрэглэх хэрэгтэй. Эцэст нь 10 жилд сурах сүүлийн жилээ ангийнхантайгаа дурсамжтай өнгөрүүлээрэй. 10 жилдээ дахин сурахгүй шүү дээ. ЭЕШ-д бэлдэхдээ орой эрт унтаж өглөө эрт босвол их сайн. Цагийг дэмий үрэлгүй өөрийнхөө төлөө хийж байгаа шүү гэдгээ үргэлж санаж багш нарынхаа үгэнд сайн орж байгаарай. 800 оноо авах боломж хүүхэд болгонд байдаг. Тэр боломжоо ашиглах эсэх нь өөрөөс чинь шалтгаална гэдгийг санаарай.

За баярлалаа. Цаашдын сурлагад тань илүү их амжилт хүсье.

Танд ч бас баярлалаа. Ажилд тань амжилт хүсье.

Ярилцсан: БҮТ-ийн мэргэжилтэн Ш.Сувдмаа